

АГУУЛГА

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл	2
1.2 Төслийн талбайн байршил	2
1.3 Уурхайн үндсэн процесс, ашиглалтын систем, хүчин чадал, ажиллах горим	3
1.4 Уурхайн үндсэн тоног төхөөрөмж, дэд бүтэц:	8
1.6. 2025 оны Уулын ашиглалтын ажлын төлөвлөгөө	10
БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	10
2.1 Орон нутгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал:	10
2.2 Байгаль орчны төлөв байдал:	10
Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	12
БҮЛЭГ IV. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	14
БҮЛЭГ V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
БҮЛЭГ VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	28
БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	28
БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ X. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ XI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
БҮЛЭГ XII. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	33
БҮЛЭГ XIII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН	36
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	36
БҮЛЭГ XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	38

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл


Төслийн нэр:	“Дожир нэртэй хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах” төслийн Баяжуулах үйлдвэр
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж, байгууллагын нэр:	“Ханшашир” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9019058081 Регистрийн дугаар: 2618176
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 3 оргил хотхон 62-1 тоот
Байршил:	Хэнтий аймгийн Баян-Овоо сумын 2-р баг
Утас:	+976-86089010, +976-99055718
Мэйл хаяг:	khorloogerelmaa@gmail.com
Төслийн зорилго:	Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт орших “Дожир” хайлуур жоншны ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.
Тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-016819
Талбайн хэмжээ:	98.37 гектар
Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хууль эрх зүйн хүчинтэй баримт бичгийн жагсаалт	“Дожир” хайлуур жоншны ордод 2019 онд явуулсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн дүгнэлт Дугаар: ХХ-02-01, Огноо: 2022-02-18
	ТЭЗҮ хүлээн авсан ЭБМЗ-ийн дүгнэлт: Дугаар: Т/22-09-03, Огноо: 2022-09-15
	ТЭЗҮ хүлээн авсан АМГ-ын даргын тушаал: Дугаар: Т/183, Огноо: 2022-10-24

1.2 Төслийн талбайн байршил

Уурхайн ашиглалтын талбай нь Хэнтий аймгийн Баян-Овоо сумын 2-р багийн нутаг дэвсгэрт харьяалагддаг ба Улаанбаатар хотоос зүүн зүгт 420 км, Хэнтий аймгийн төв Чингис хотоос 100 км, Баян-Овоо сумын төвөөс баруун зүгт 25 км-т байрладаг.

Хүснэгт 1. Ашиглалтын талбайн солбицол

Тусгай зөвшөөрлийн дугаар	Хүчинтэй (он/сар/өдөр)	Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
			градус	минут	секунд	градус	минут	секунд
МУ-016819	2014-11-25-аас 2041-04-28 хүртэл	1	111	47	51.00	47	44	12.00
		2	111	47	00.00	47	44	12.00
		3	111	47	00.00	47	44	42.00
		4	111	47	51.00	47	44	42.00



Зураг 1 “Дожир уурхай”-н байршлын зураг

1.3 Уурхайн үндсэн процесс, ашиглалтын систем, хүчин чадал, ажиллах горим

Уурхайн үндсэн процесс: Далд уурхайн уулын ажил нь нэвтрэлтийн болон нураалтын бие даасан ажлын нийлбэр байдаг. Ашигт малтмалыг олборлохын тулд гадаргаас ашигт малтмалын олборлох мөргөцөг хүртэл бий болгосон газар доорх уулын малталтуудын цогцолборыг барьж байгуулах ажил нь нэвтрэлтийн ажил юм. Нэвтрэлтийн ажлаар гадаргаас хүдрийн биетийн нөөц тогтоогдсон гүний доод хязгаар хүртэл хажуугийн бат бэх чулуулгийн дундуур нэвтрэх босоо ам, судлын биетийг ашиглах зохистой өндөр бүхий давхруудад хуваасан түвшингүүдийг холбосон малталт, судлын биетийн суналд хөндлөн квершлаг малталт, квершлагаас хөндлөн буюу суналын дагуу хажуугийн чулуулаг дундуур нэвтрэх штрек, штрекээс хөндлөн нэвтрэх судлыг зузааныг нь бүрэн огтлох орт, судлыг блокуудад хуваах восстающий зэрэг үндсэн болон бэлтгэл малталтуудыг байгуулдаг. Далд уурхайн нэвтрэлтийн уулын ажлын процесс зохион байгуулалт нь бие биеэсээ

хатуу хамааралтай, дэс дараалалтай байдаг учир процесс бүрийг нарийвчлан тодорхойлж, ялангуяа малталт нэвтрэлтийн ажлын мөчлөг бүрийг тодорхойлох шаардлагатай.


Босоо ам нь амсар дээрээ чиглүүлэгч дамар, вагон хөмрөгч, бункер бүхий цамхагтай бөгөөд ашигт малтмал, хоосон чулуулаг, хүн материал тээх клет төхөөрөмж, шугам хоолой, клет өргөх машин /газар дээрх/ бүхий цогцолбор байгууламж юм.

Хэвтээ малталтууд болох квершлаг, штрек, уклон нь босоо амнаас ашигт малтмалын мөргөцөг хүртэл хэвтээ чиглэлээр нэвтэрдэг. “Дожир” ордыг ашиглах далд уурхай нь бага хүчин чадал бүхий уурхай хэдий ч цаашид нөөц өсөх боломжтой учраас манай оронд түгээмэл практик болох төмөр замтай хэвтээ малталтуудаар ашиглах нь оновчтой гэж үзэж байна. Энэхүү төсөлд төмөр замын явах анги бүхий ачигч машин, тэргэнцэр ажиллуулна.


Үндсэн процесс							
1. Бэлтгэл ажил	2. Өрөмдөх	3. Тэслэх	4. Агааржуулах	5. Ухаж ачих	6. Тээвэрлэх	7. Зам тавих, шугам татах	8. Бэхэлгээ тавих
Туслах процесс							

Ашиглалтын систем, ажиллах горим:

Богино орлоор олборлох баганат ашиглалтын систем: Энэ систем нь хүдрийн штрекээс хүдрийн биетийн уналын эсрэг чиглэлтэй 4 метр өргөнтэй хоорондоо 14 метрийн зайтай орлууд нэвтрэнэ. Учир нь таазны чулуулгын тогтворжилтоос хамааран орол хоорондын өргөнийг 20 метрээс ихгүй, орлын өргөнийг 3-5 метрээр авдаг. Орол хоорондын хүдрийн биетийг олборлоход хүдрийг хязгаарлаж буй буюу захын 2 орлоос дотогш чиглэлтэй шпур өрөмдөн нураана. Хүдрийн биетийн уналын дагуух дундаж өнцөг нь 37^0 тул хүдэр өөрийн жингээр буухгүй. Иймд скреперийн тусламжтай хүдрийг хүдэр буулгуур руу буулгана. Хамгаалалтын тулгуур баганын хувьд модон бэхэлгээ ашиглана. Олборлож дууссан блокийн тулгуур баганын 40-50%-ийг эргүүлэн авна. Тус ашиглалтын системийг ашиглах нь аюул осол багатай, хөдөлмөрийн аюулгүй байдал талаасаа аюулгүй юм. Мөн бэлтгэл ажил багатай, оролууд нэвтэрч эхэлсэн үеэс хүдэр гаргаж эхэлдэг учир нэгэн зэрэг хэдэн ч оролыг зэрэг нэвтрэх боломжтой харьцангуй бүтээл өндөртэй байдаг




Зураг. Скрепер



Зураг 3. Богоно орлоор олборлох баганат ашиглалтын системийн олборлолтын дараалал

Хүдэр хоршоолох ашиглалтын систем: Энэ системд камерыг доороос дээш нь олборлох ба нураасан хүдрийг хоршоолон ажиллах ажилчид 2- м-ийн өндөртэй орон зайг үлдээн тэндээс шпур өрөмдөн олборлолтыг явуулах учир өрөмдлөгийн малталт шаардахгүй сайн талтай. Мөргөцгөөс хүдрийг тэсэлж нураасны дараа түүний 25-35 хувийг доош нь буулгана.



Зураг 4. Хоршоолон олборлох ашиглалтын систем

Энэ ашиглалтын системүүдийн дутагдалтай тал нь:

- ❖ Хажуугийн чулуулгийг нурааж хүдэр буулгах орон зайг ихэсгэх нь хүдрийг их хэмжээгээр бохирдуулах

Давуу тал нь:

- ❖ Шпур өрөмдөн олборлолтыг явуулах учир өрөмдлөгийн малталт шаардахгүй

Давхрын өндөр нь ихэвчлэн 50-60 м-ээс ихгүй байна. Хэрэв өндөр нь хэт их байвал хоршоолсон хүдрийн гадаргууг жигд байлгахад хүндрэл учирна. Хэвтшийн хязгаар нь зөв, хажуугийн чулуулаг нь тогтвортой байхад блокийн урт нь 40-50 м-ээс 80-100 м хүртэл байж болно. Блок хоорондын цулын өргөн ба доод хэсгийн зузаан нь зөөх түвшинтэй үед 6-10 м, таазны цулын зузаан нь хатуу, тогтвор сайтай бага зузаантай хүдрийн биед 2 м, дунд зэргийн зузаан хүдрийн биед 5-10 м байна.

Уурхайн олборлолтын хүчин чадал, ажиллах горим: Дожир хайлуур жоншны ордыг түшиглэн байгуулах уулын үйлдвэрийн хүчин чадал нь уурхайн жилийн хүчин чадлаас шууд хамаарна. Сонгосон далд аргаар хоршоолон олборлох ашиглалтын систем нь харьцангуй бүтээл багатай байдаг бөгөөд далд уурхайн олборлолтын хүчин чадал нь дараах хүчин зүйлүүдээс ихээхэн шалтгаалдаг. Үүнд:

- Үндсэн болон бэлтгэл малталтуудын нэвтрэлтийн ажлын хурд, хэмжээ,
- Олборлолтод бэлтгэх буюу нураалтын ажлын эзлэхүүн, хэмжээ, хурд,
- Уул техникийн нөхцөлүүд болох уулын даралт, ус, хагарал, нуралт гэх мэт.

Уурхайн жилийн хүчин чадлыг хүдрийн биетийн зузаан, уналын өнцөг, техник технологийн боломж, хөрөнгө оруулалт зэрэг үзүүлэлтүүдээс хамааруулж дараах байдлаар тооцсон.

Далд уурхайн үйлдвэрлэлийн хүчин чадал нь тухайн уурхайн нэг жилд олборлох хүдрийн боломжит дээд хэмжээгээр тодорхойлогдоно.

Хүснэгт 2. Далд уурхайн жилийн хүчин чадал

№	Үзүүлэлт	Х.н	Үзүүлэлт
1	Олборлолтын ажлын жилийн дундаж гүнзгийрэлт	м	25
2	Хүдрийн биетийн зузаан	м	0.9
3	Суналын дагуу урт	м	304
4	Уналын дундаж өнцөг	градус	50
5	Уналын өнцөг тооцсон коэффициент		0.9
6	Хүдрийн биетийн дундаж зузааныг тооцсон коэффициент		1.3
7	Ашиглалтын систем тооцсон коэффициент		1.2
8	Нэг зэрэг ашиглах давхрын тоо		1
9	Нэг зэрэг ашиглах давхрын тоог тооцсон коэффициент		1
10	Хүдрийн эзлэхүүн жин	тн/м3	2.8
11	Хаягдлын хувь	%	5.0%
12	Бохирдлын хувь	%	23.6%
13	Тооцоолсон жилийн хүчин чадал	мян тн/жил	32149.8
14	Сонгож авсан жилийн хүчин чадал	мян тн/жил	30000.0

Бэлтгэл огтлолын ажил хангагдсанаар уурхайн жилийн хүчин чадлыг 30000 тн/жил хүдэр олборлохоор тооцлоо. Далд уурхай эхний жил 23000 тн, 2 дахь жилээс бүрэн хүчин чадлаараа буюу 30000.0 тн хүдэр олборлохоор тус тус тооцов.

Ашиглах хугацаа: Далд уурхай нь бүрэн хүчин чадалдаа хүрэхээс өмнө газрын дээрх, доорх барилга байгууламжийн ажил, газрын гүн дэх үндсэн малталтуудыг нэвтрэх, тэдгээрийг бүрэн тоноглож бэхлэх, нээх бэлтгэл малталтуудыг нэвтрэх, түүнээсээ олборлолтод бэлтгэх малталтуудыг нэвтрэх хүдрийг олборлолтод бэлтгэх нураалтын ажлуудыг хийх тул олборлолтын ажил эдгээр ажлууд хийгдсэний дараа бүрэн хүчин чадлаараа ажиллах ба ашиглалтын хоёр дахь жилээс эхлэн 30000 тн хүдэр олборлох ба одоогийн нөөцийг 4 жилийн хугацаанд ашиглахаар байна.

Уурхайн ажиллах горим: Далд уурхайн ажиллах горим нь жилд 343 хоног тасралтгүй олборлолтын ажил явуулан хоногт 2 ээлжээр ажиллана. Ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг, ээлжийн цаг ашиглалт 76% байна.

Далд уурхайд орж ирэх усыг зайлуулах, мөргөцгийг хуурайшуулах ажил: Төлөвлөж байгаа уурхайн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, найдвартай явуулахад далд уурхайн мөргөцөгт

орж ирэх усыг зайлуулах, хүдрийн биет, түүнийг агуулагч чулуулгийг, уурхайн мөргөцгийг хуурайшуулах, шүүрүүлэх ажлыг зайлшгүй гүйцэтгэнэ.

-Дренажийн сувгаар далд уурхайн мөргөцгийн хамгийн нам дор хэсэгт (зумпфэнд) хуримтлуулан ус өргөх шахуургын (насос) тусламжтайгаар гүйцэтгэнэ.

-Ус шүүрүүлэх ажлыг уурхайн мөргөцөгт орж ирэх усны хэмжээнээс хамааран тусгайгоримыг баримтлан (тасралтгүй, тодорхой хоног, цагаар г.м) ажиллана.

Эхний ээлжид далд уурхайн мөргөцөгт орж ирэх усыг дренаж ашиглан хамгийн нам доор хэсэгт байгуулсан зумпэнд хуримтлуулан 10-15 м³/цаг хүчин чадалтай зөөврийн шахуургаар шавхана. Усыг тусгай хоолой ашиглаж 1-2 км-т орших хуурай сайраар дамжуулан хиймэл нуурт хүргэж ажиллана.

Далд уурхайн гэрэлтүүлэг: Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмээр газрын доор шат, хүн явах зам, тээврийн зам болон бүх ажлын байрууд нь үл хамаарах тэжээл бүхий үндсэн болон ослын гэрэлтүүлэгтэй байна. Ослын гэрэлтүүлэгт малгайн гэрэл хэрэглэнэ. Далд уурхайн квершлагтээврийн штрекийн гэрэлтүүлгийн норм 2 Лк байна. Эдгээрийн гэрэлтүүлэгт 220В-ийн 80Вт- н чадалтай өдрийн чийдэн бүхий далд уурхайн зориулалттай РВЛ-80 төрлийн гэрэлтүүлэгч хэрэглэнэ. Гэрэлтүүлгийн норм ёсоор тэдгээрийг 12м-н зайтай байрлуулна.

Уурхайн агааржуулалт: Далд уурхайн агааржуулалт нь уулын малталтын агаарын бүрэлдэхүүнийг техникийн дүрмийн дагуу тогтмол байлгах зорилготой.

Далд уурхайн малталтын агаарын найрлага нь атмосфер дахь агаараас малталт руу орсон агаар малталтын чулуулаг болон тоосонцортой харилцан үйлчлэлд орж исэлдэн янз бүрийн хий ялгарах процессод өөрчлөлтөд орж нүүрсхүчлийн хий, хүхэрт хий, хүхэрт ус төрөгч, нүүрсхүчлийн исэл, метан, устөрөгч зэрэг хий болон тоосоор бохирддог.

Тэсэлгээний ажлын дараа уурхайн агаар азотын исэл, устөрөгчийн ислээр бохирддог ба далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэмд уурхайн агаарын найрлагад байх хүчилтөрөгч 20% иас багагүй, хорт хийний агууламжийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг заасан байдаг ба дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 25. Хорт хийний агууламжийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

№	Хорт хий	Химийн томьёо	Зөвшөөрөгдөх хэмжээ	
			%	мг/м ³
1	Нүүрс хүчлийн исэл	CO	0.0017	20
2	Азотын исэл	NO ₂	0.00026	5
3	Хүхэрлэг хий	SO ₂	0.00038	10
4	Хүхэрт устөрөгч	H ₂ S	0.00071	10

Малталтуудыг агааржуулахад дараах үндсэн 3 аргыг хэрэглэнэ. Үүнд:

- Шахах,
- Сорох,
- Хосолсон.

Шахах арга: Энэ аргыг шатах (метан, устөрөгч) эсвэл хорт (хүхэрт устөрөгч, хүхэрт хий нүүрстөрөгчийн исэл) хий ялгарч болзошгүй уулын малталтад хэрэглэнэ. Энэ арга нь мөргөцөг орчмыг сайн агааржуулдаг боловч хорт хийг малталтын уртын дагуу тарааж түүнийг бүрэн арилгахын тулд нэлээд хугацаа зарцуулах шаардлагатай байдаг дутагдалтай.

Сорох арга: Энэ аргыг хорт болон тэсэлгээний үед ялгарах хий байхгүй нөхцөлд хэрэглэнэ. Энэ аргын сайн тал нь малталтын агаарын орчинг цэвэр байлгадаг. Дутагдалтай тал нь агаар дамжуулах уян хоолой хэрэглэж болдоггүй.

Хосолсон арга: Энэ аргын үед дээрх 2 аргын хослолыг хэрэглэдэг. Хосолсон аргаар агааржуулахын тулд шахах үйлчилгээтэй богино урттай агаар дамжуулах хоолойг мөргөцгийн ойролцоо байрлуулж, сорох ажиллагаатай агаар дамжуулах хоолойг мөргөцгөөс 10-20 метрийн зайнаас эхлэн малталтын бүх уртын дагуу байрлуулдаг. Энэ аргыг харьцангуй их урттай малталт нэвтрэх үед хэрэглэдэг.

Хоршоолон олборлох аргаар ашигт малтмал олборлох процессод агааржуулалтын үндсэн зарчим нь блокийн нэг талын восстающийгаар дамжин мөргөцөг уруу орж агааржуулаад бохирдсон агаар нөгөө талын восстающийгаар гарч агааржуулалтын штрект ордог.

Агааржуулалтын тооцоо: Агааржуулахдаа босоо малталтыг 12м-ээс дээш гүн нэвтрэх үед ажиллагсдын аюулгүй ажиллагааг хангах үүднээс 25 кВ-ын хүчин чадалтай вентилятороор, агааржуулалтын хоолойн тусламжтайгаар агааржуулна.

Өрөмдлөг тэсэлгээний ажил хийсний дараа малталтыг бүрэн агааржуулж /30 минутаас доошгүй/ бохир агаарыг зайлуулсны дараа уурхайн инженер нэг хүний хамт хорт хий шалгахзориулалтын аппаратаар тэсэлгээний мөргөцгийг шалгаж, аюулгүй болохыг мэдсэний дарааажлаа эхэлж байх шаардлагатай. Вентиляторыг уурхайн аманд /газрын гадаргад/ уурхайгаасгарах бохир агаарыг эргүүлэн сорж орлуулахгүйгээр зайд байрлуулна.

Далд уурхайн агаарын температур: Уулын малталтын агаарын температур нь малталтыг хүрээлэн буй орчны температураас хамаарна. 25-30 м-ийн гүнд агаарын температур нь газрын дээрх температурын жилийн дундажтай тэнцүү. Уурхайн агаарын хэвийн температур $t^0=15^0\text{C}$. Уурхайн гүн ихсэхтутам агаарын температур тодорхой зайд 1^0 -аар нэмэгдэнэ. Уурхайн гол амаар агаарыг дээшнь гаргахад тэр нь тэлэлтэнд орж дулаан шингээлт явагдаж 100 м тутамд $t^0=0.8-0.9^0\text{C}$ -ээр буурдаг. Уулын чулуулгаас малталтын агаарт өгөгдөж буй дулааны хэмжээ нь чулуулаг ба агаарын температурын ялгавар, чулуулгийн дулаан гаргалтын коэффициент, агаарын хурд, бусад хүчин зүйлээс хамаарна. Эрүүл ахуйн дүрмийн дагуу ажлын байран дахь хамгийн бага температурыг нормчлох бөгөөд уурхай доторх ажилчид байрлах, ажиллах газрын хамгийн их температурын хэмжээгдараахи хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 32. Ажилчид байрлах ажиллах газрын хамгийн их t^0 хэмжээ

Агаарын максимал температур C^0	Агаарын максимал температур (тодорхой агаарын урсгалын хурдын үе дэх)(^0C) м/с							
	1	2	3	4	5	6	7	8
28	10	12	14	16	18	20	22	24
26	9	11	13	15	17	19	21	23
24	8	10	12	14	16	18	20	22
22	7	9	11	13	15	17	19	21
20	6	8	10	12	14	16	18	20

Агаар оруулдаг босоо аманд орж буй агаарыг халаах тоног төхөөрөмж суурилуулна. Энэ тоног төхөөрөмж нь уурхайн босоо гол амын уулзвараас доош 5 м-ийн гүнд байрлана. Тус халаагуур нь агаарын температур +2 хэмээс доошгүй дулаантай байлгах үүрэгтэй. Галаар ажилладаг халаагуур хэрэглэхийг хориглоно.

1.4 Уурхайн үндсэн тоног төхөөрөмж, дэд бүтэц:

Барилга байгууламж: “Ханшашир” хайлуур жоншны ордыг ашиглах далд уурхайн гадаргуугийн барилга байгууламжуудад уурхайн хэвийн ажиллагааг хангахад зориулагдсан дараах барилга, байгууламж зайлшгүй байх шаардлагатай. Үүнд:

-  Далд уурхайн барилга байгууламж
-  ШТС
-  Уурхайн захиргаа
-  Ажилчдын байр, хоолны газар, халуун ус
-  Тэсрэх бодисын агуулах, зэрэг дээрх дэд бүтцийн барилга байгууламжуудыг шинээр барьж байгуулахаар ТЭЗҮ-д тусгасан болно.
-  Далд уурхайн үндсэн барилга байгууламжид хүдрийн биетийг нээхэд зориулагдсан газрын гадаргуугаас шинээр нэвтрэх гол ам түвшний агааржуулалтын болон уурхайн их амнуудын ойролцоох байгууламж, квершлаг, штрек зэрэг малталтууд хамаарагдаж байна.
-  Уурхайд ажиллах ажилчид нь уурхай дээр байрлах бөгөөд сэндвич хавтангаар барьсан уурхайн оффис 25 м² болон ажилчдыг байршуулах ажилчдын сууц 275 м² нэг давхар

байрнууд, уурын зуух халуун усны байр, хоолны газар, агуулах бүхий цогцолборыг барьж байгуулна.

- ✚ Уурхайн дэргэд тэсрэх бодис, тэслэх хэрэгслийн агуулах, түлшний агуулах байхаас гадна уурхайн цахилгааны шугам, дэд станц зэрэг дэд бүтцийн бусад барилга байгууламжууд байх болно.

Цахилгаан хангамж: Чингис-Батноров чиглэлийн 110/35/6 кВт-ын өндөр хүчдэлийн шугамаас салаалсан Батноров-Баян-Овоо-Түмэнцогт чиглэлийн 110/10 кВт-ын өндөр хүчдэлийн шугамаар холбогдсон. Тус орд нь Баян-Овоо сумын төвөөс 25 км зайтай ба өндөр хүчдэлийн шугамд бүрэн холбогдсон.

Уурхайн дотоод холбоо, дохиоллын систем: Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн дагуу босоо амны нэвтрэлт гүнзгийрэлтийн үед өргөх төхөөрөмж бүр өөр хоорондоо хамааралгүй 2-оос доошгүй дохиоллын системээр тоноглогдсон байх шаардлагатай.

“Дожир” уурхай нь доорх төрлийн холбоо, дохиоллуудыг хослуулж ашиглана. Үүнд

- а). Утсан болон радио харилцааны систем;
- б). Уурхайн ослын дохиоллын систем;
- в). Технологийн хэсгүүдэд хэрэглэх анхааруулах болон ажлын дохиоллын систем /өргөх, тээвэрлэх, мөргөцөгт г.м/;
- г). Уурхайн диспетчерийн холбооны систем.

Газрын дээр гол агааржуулах сэнсний байр; Босоо гол амны эхлэл ба төгсгөлд;

Ус татах төхөөрөмжийн (насосны) дэргэд; Уулын ажлын түвшин бүрд тус бүр нэг;

Үйлдвэрийн талбайд уурхайн дарга, ерөнхий инженер, эмч, диспетчерийн өрөөнд тус бүр нэг ширхэг, нөөцөд хоёр ширхэг, нийт 12 ширхэг тавина.

Богино долгионы утасны тоо бүртгэл, техникийн бэлэн байдлыг диспетчер хангаж ажиллана.

Богино долгионы станц нь үйлдвэрлэгдсэн улс орон, маркийн хувьд дурын байж болох ба дараах шаардлагыг зайлшгүй хангасан байх ёстой. Үүнд:

а/ аппаратын дотоод цэнэг барих хугацаа – 8 цагаас багагүй;

б/ дахин цэнэглэгдэх хугацаа – 2.5 цагаас ихгүй;

в/ газрын дор 100м-ээс ихгүй гүнд харилцах техникийн чадвартай.

Зам, харилцаа, холбоо: Уурхай нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой зорчих, ажилчид тээвэрлэх, сэлбэг материал хэрэгсэл хүргэх зэрэг шаардлагатай үед аль ойрын аймаг, сум, суурингуудаас буюу Хэнтийн аймгаас тээвэрлэнэ. Харилцаа холбоонд уурхайд богино долгионы радио станцыг ашиглах ба уурхайн орчимд Unitel, skytel үүрэн телефоны сүлжээ бүрэн нэвтэрсэн тул харилцаа холбоогоор бүрэн хангагдана.

Усан хангамж: Ажилчдын унд ахуй, баяжуулах үйлдвэр болон нөхөн сэргээлтэд ашиглах усыг тус “Ханшашир” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайн баруун урд хэсэгт байрлах өөрийн эзэмшлийн гүний худгаас (Худгийн байршил /111°47'13"/ 47°44'16" ундрага 6.5 л/сек) авч ашиглана. Унд ахуй, баяжуулах үйлдвэр болон нөхөн сэргээлтэд шаардлагатай тохиолдолд зам усалгаанд ус хэрэглэхээр тооцсон. Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээг өөрийн эзэмшлийн гүний худгаас зөөвөрлөн ашиглах бөгөөд 80 хувийг эргүүлэн ашиглах, 20 хувийг нөхөн сэлбэлтээр ашиглана.

Далд уурхайд өрмийн перфоратор /4л/мин/-ын ашиглалтын үед, бэхэлгээ шүрших үед /1м³ бэхэлгээнд ойролцоогоор 0.2 м³ ус/ хэрэглэнэ. Жилд нэвтрэх малталтын хэмжээ, хүдэр нураалт зэргийг харгалзан тооцож усны хэрэгцээний тооцоог орууллаа.

Уурхайд нийт 89 хүн, жилд нийт 343 хоног ажиллана. Төслийн ашиглалтын жилүүдэд нийт 20012.2¹ м³ ус хэрэглэх бөгөөд үүнээс унд ахуйд 18316.2 м³ ус, шаардлагатай тохиолдолд зам талбайн тоосжилт дарах усалгаанд 704.0 м³, уурхайн нөхөн сэргээлтэд нийт 992.0 м³ ус ашиглагдахаар байна. /Ус хэрэглээний нормыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын дагуу баримтлах нормоор тооцов/.

¹ Ерөнхий үнэлгээний дүгнэлт Онцгойлон анхаарах зүйлс /3/

1.6. 2025 оны Уулын ашиглалтын ажлын төлөвлөгөө

Хүдрийн хаягдал олборлолтын хэмжээнд нийт хаягдал 5.0%, бохирдол 21.8% байна. Уурхайн хүрээнд 2025 онд олборлох геологийн нөөцийг 46.85 мян.тн хүдэр байхаар тооцож үүнээс хаягдал бохирдлыг тооцсоноор нийт үйлдвэрлэлийн нөөц 54.75 иян.тн хүдэр, 55.6% агуулгатай 30.4 мян.тн хайлуур жоншны нөөцийг олборлохоор байна.

“Ханшашир” ХХК-ийн Дожир хайлуур жоншны ордын далд уурхайн олборлолтоос гарсан хүдрийг тусгай талбайд асган гараар ялгах бөгөөд гар ялгалтаас хаягдсан бага агуулгатай хүдрийг төслийн талбайгаас 0.5км-ийн зайд Ханшашир ХХК-ийн Жонш баяжуулах үйлдвэрт нийлүүлнэ.

Гар ялгалтаар 2025 онд ФК-92 маркийн 5 мян.тн баяжмал гарган авах бөгөөд гар ялгалтаас гарсан бага агуулгатай 55.6%-ийн агуулгатай 68.68 мян.тн хүдрийн Ханшашир ХХК-ийн жонш баяжуулах үйлдвэрт нийлүүлнэ.



Зураг 2. Баяжуулах үйлдвэр

БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Орон нутгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал:

Хэнтий аймгийн Баян-Овоор сум нь засаг захиргааны хувьд 4 багт хуваагддаг. Үүнд: Дэлгэрхаан (1-р баг), Наран (2-р баг), Сүмбэр (3-р баг), Жавхлант (4-р баг), уурхайн хамгийн ойр орших төв суурин газар нь Баян-Овоо сумын төв юм. Улаанбаатар хотыг зүүн аймгуудтай холбосон автомашины хатуу хучилттай замаас 25км-т байршдаг. Сумынхаа баруун талаар Батноров, хойд талаараа Норовлин, зүүн талаараа Дорнод аймгийн Хөлөнбуйр, урд талаараа Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түмэнцогт сумдын нутаг дэвсгэртэй хиллэдэг бөгөөд 338.1 мян.га нутаг дэвсгэрийг эзлэн оршдог. 2023 оны жилийн эцсийн байдлаар 2000 гаруй хүн амтай, 1052 өрхтэй, 205788 манган толгой малтай байна. Хүн амын үндсэн хэсэг нь халх үндэстэн. Амьжиргааны эх үүсвэр нь мал аж ахуй бөгөөд сум суурин газарт төрийн байгууллагад ажиллах болон худалдаа наймаа эрхлэн амьдарна. Малтай өрх сумын нийт өрхийн 88.8%-ийг эзэлж байна. Үүрэн телефоны бүх сүлжээнд холбогдсон.

2.2 Байгаль орчны төлөв байдал:

Төслийн талбайн газрын гадарга, физик газарзүй: Монгол орны газар зүйн мужлалаар тал хээрийн болон Хангайн бүсийн заагт орших учраас гадаргын хувьд намхавтар, нам дов толгодорхог болон

нам уулын рельеф зонхилж байдаг. Гадарга нь тэгш оройтой, налуу, хажуутай жигд үргэлжилсэн маягийн толгодтой. Хүдрийн талбайн хувьд үнэмлэхүй өндөр нь далайн түвшинээс дээш 995-1010м байх бөгөөд гадаргын харьцангуй өндөр нь 10-20м байдаг.

Уур амьсгал: Ордын нутаг дэвсгэр нь бүхэлдээ эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд хамаарна. Ажиглалтаас үзэхэд цаг уурын температур эрс хэлбэлздэг, хур тунадас багавтар, агаар чийгшилт харьцангуй бага хуурайвтар байдаг. Сарын хамгийн бага дундаж температур нь 1-р сард -22-32°C, хамгийн өндөр дундаж температур нь 7-р сард 20°+25°C байдаг ба дулааны улирал 9-р сар дуустал үргэлжилдэг. Хур тунадас жилд дунджаар 160-180мм хүрнэ. Энд баруун хойноосоо чиглэлтэй салхи зонхилно. Салхины хурд 2.8-7.3м/сек хүртэл хурдасч шороон ба цасан шуурга шуурч хүчтэй салхилах болсон.

Геологийн тогтоц: Төслийн талбай нь Баянхонгорын структур-металлогенийн бүсийн Байдрагийн өргөгдөл, Хөх булаг алтны хүдэржилт, алтны шижирмэг хуримтлал бүхий талбайн хэмжээнд байрлана. Талбайн стратиграфийн ангиллыг 2011-2014 онд явуулсан УГЗ-200 төслийн хэмжээнд зохиогдсон 1:200000 болон Д.Андреас нарын 1966-1969 онд явуулсан 1:100000-ны геологийн зураглалын ажил гүйцэтгэж явуулсан. Хөх булагийн алт, зэсийн орд нь клино-пироксен-гранаттай скарны 11 биетээс бүрддэг. Эдгээр биетүүд нь ихэнхи нь боржиндиоритын массиваас 100-500 м зайд алслагдсан, зарим нь хиллэсэн хүдэржилт нь гантигжсан шохойн чулууны үелэл ан цавын дагуу 0.01-0.4 м үүр хэлбэрээр илэрдэг ба скарны биетүүд нь халькопирит, борнитийн шигтгээ, оюу, номингийн өнгөр, хааяа гадаргуугаас авсан цэгэн сорьцоос 1 мм хүртэл хэмжээтэй алтны мөхлөг агуулах бөгөөд алтны агуулгыг 0.1-10.6 г/тн гэж Д.Андреас тодорхойлсон. Харин 1995-1998 оны судалгаагаар скарны хүдэржилтээс авсан цэглэн сорьцны химийн шинжилгээгээр алтны агуулга 4.9-20.69 г/тн, 2.14-125.5 г/тн-ы мөнгөний агуулгыг тогтоосон байдаг.

Хөрс: Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй. Талбайн хэмжээнд хүрэн, цайвар хүрэн, бор хүрэн хөрс зонхилох ба голдуу элсэнцэр, шавранцар агуулна. Хужирлаг цайвар шаргал хөрс нь эх газрын нуурын гаралтай шавранцараас тогтоно. Хөрсний ялзмагт үеийн зузаан нь 0.15-0.2м хааяа 0.3- 0.4м хүртэл хэлбэлзэнэ. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хонхор хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл хажуу нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн. Ургамлын бүрхэвч бүрдүүлэгч гол нэр төрлийн өвс ургамал нь шивээ, хялгана, хазаар, агь, таана, хөмүүл, шарилж, божмог гэх мэт. Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хонхор хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл хажуу нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн байдаг.

Гидрогеологи, усан сүлжээ: Гадаргуугийн усан сүлжээний хувьд булаг, шанд, хуурай сайруудтай. Түр зуурын урсгал усны нөлөөгөөр үүссэн жалга сайрууд нь гүн биш ховил үүсгэх ба нэг их урт үргэлжилдэггүй. Хуурай сайрууд нь зун болон намрын улиралд усархаг бороо орсны дараа түр хугацааны урсгал устай байх бөгөөд цугларсан ус нь томоохон хөндийнүүдэд шалбааг тойром үүсгэнэ. Энэ нь багавтар хугацаанд тогтоод хур тунадас дахин орж тэжээгдэхгүй бол хатаж ширгэн алга болдог. Ордын орчимд талбайгаас 8км зайтай Хэрлэн гол урсах ба бороотой үед түр зуурын урсгалтай горхи хөндий амууд даган урсдаг.

Амьтан, ургамлын аймаг. Амьтан ургамлын аймаг болон уур амьсгалын хувьд говь, тал хээрийн аль алиных нь шинжийг агуулсан холимог байдалтай. Ургамлын аймаг харьцангуй сийрэг тачирхан ургасан өвстэй бөгөөд илчлэг, тэжээллэг чанартай байдаг. Энд таана, хөмүүл, ерхөг зэрэг ургамал ургах бөгөөд бороо хур элбэгтэй цаг агаарын тааламжтай нөхцөлтэй үед ургамал харьцангуй сайн өтгөн ургадаг.

Ан амьтны хувьд харьцангуй төрөл зүйлийн хувьд багавтар байдаг. Энд тарвага, зурам, оготно, цагаан зээр, үнэг, хярс, туулай, чоно байхаас гадна жигүүртэн шувуудаас сар, тас, элээ хааяа талын бүргэд байна. Жижиг хорхой шавьж харьцангуй элбэг.

Түүх, соёлын дурсгалт зүйлс: “Ханшашир” ХХК нь MV-016819 тоот тусгай зөвшөөрөлтэй 98.37 га талбайд 2019 оны 10-р сарын 25-31-ний өдрүүдэд археологийн авран хамгаалах хайгуул судалгааг зохион явуулсан. Үүний үр дүнд эртний булш, хэрэм бэхлэлт, чулуун зэвсгийн бууц суурин болон хадны зураг, хөшөө чулуу, эртний үйлдвэрлэлийн ул мөр гэх мэт археологийн дурсгал түүнчлэн, хожмын үед хүний гараар бүтээсэн соёлын ямар нэг ил харагдах дурсгал, төмөрлөг эдлэл болон шавар ваар, шаазан сав суулганы хагархай зэрэг хаягдмал эд өлгийн зүйл өнгөн хөрсөн дээр илрээгүй. Мөн тахилгатай уул болон ардын зан үйл явуулдаг газар орчин үеийн өвөлжөө бууц талбайн дотор байхгүй байна.²

Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн тавдугаар бүлгийн 27-р зүйлийн 8-рт заасны дагуу 2019 оны 11-р сарын 22-нд Палеонтологийн хайгуул, судалгааны ажлын тайланг хийж гүйцэтгэсэн байна. Тусгай зөвшөөрлийн талбайд эртний сээр нуруугүйтэн амьтдын төлөөлөгч болох, усны дун, хясаа, остракод, ургамлын үлдэгдэл агуулагч доод цэрдийн Цагаанцав формацын хөрзөн элсжингийн зузаалаг дээр нийцлэг хучсан дан ганц хүрмэн, андезит-хүрмэн, андезит, тэдгээрийн нүх сүвэрхэг, бүйлслэг, цул, хааяа агломерат, бөсөл зэрэг хурдас хуримтлал талбайд тархсан байна. Талбайн гадаргууд илэрсэн дээрх насны хурдасд эртний амьтан, ургамлын хайгуулын ажлыг хийж гүйцэтгэсэн. Судалгаагаар ямар нэгэн эртний амьтан ургамлын олдвор илрээгүй болно.

БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг тооцохдоо төсөл хэрэгжих талбайн байгаль орчны өнөөгийн төлөв байдал, ашиглах технологи, төслийн үйл ажиллагаанд хамаарах хууль эрх зүйн орчин, нийгэмд үзүүлэх эдийн засгийн үр өгөөж зэргийг үндэслэл болгосон.

“Дожир” хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төслийн үйл ажиллагааны үед байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үргэлжлэх хугацаа (богино, дунд, урт), нөлөөллийн үр дагаврыг (бага, дунд, их) нөлөөллийн магадлалыг (зайлшгүй, болзошгүй) тогтоосон.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан, Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яамны Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал” байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг **магадлан жагсаах** (checklist) аргаар үнэлсэн.

Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагааны үед 0.4 га талбайд хөрс хуулалт хийх бөгөөд газрын хэвлийд эвдрэлд оруулах
- Төслийн үйл ажиллагаанаас өртсөн газрын хэвлийд нөлөөлөх, өөрчлөлтөд орох
- Хаягдал чулуулгийн овоолгоос газрын гадарга, агаар, усан орчинд бохирдол үүсэх
- Газрын хэвлийд үүсэх хоосон орон зайд мал амьтан унах аюултай нөхцөл байдал бий болох
- Газрын хэвлийд хоосон орон зай үүссэнээр ойр орчны газрын гадаргад хөрсний нурулт, цөмрөлт бий болох
- Гадаад дотоод тээврийн зам дагуух хөрс газрын гадаргад эвдрэл үүсэх

- Уурхайн барилга байгууламж, кемп, ажлын байрны талбайн газрын гадаргад өөрчлөлт үүсэх
- Газрын хөл ургамал ихсэж хөрс доройтож, цөлжих, талхлагдах
- Газрын хэвлий ландшафтад гарсан өөрчлөлттэй холбоотойгоор экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдэд өөрчлөлт орох, амьтдын амьдрах орчин хязгаарлагдах

Төслөөс агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:

Төслийг эхлүүлснээр агаар, орчны чанарт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь дараах эх үүсвэрээс үүснэ. Үүнд:

- Өрөмдлөг тэсэлгээ, авто техникийн нөлөөгөөр тоосжилт үүсэх
- Түүхий эдийн талбай болон хүдэр буулгах бункерт тээврийн хэрэгсэл материал буулгахад тоос үүснэ.
- Хөрсний овоолго дээр тээврийн хэрэгсэл хөрс буулгах болон овоолго үүсгэх авто техникийн үйл ажиллагаанаас тоосжилт үүснэ.
- Тээврийн хэрэгслийн дуу чимээ үүсэх
- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн
- Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийн хөдөлгүүрээс гарах хийн хаягдал
- Хог хаягдлыг зориулалтын цэгт хаяж, тухай бүрт зайлуулаагүйгээс орчны агаарт муухай үнэр тархах

Төслөөс усан орчинд нөлөөлөх нөлөөлөл:

- Уурхайд нийт 82 хүн, жилд нийт 166 хоног ажиллана. Төслийн ашиглалтын жилүүдэд нийт 142579.2 м³ ус хэрэглэх бөгөөд үүнээс унд ахуйд 1089.0 м³ ус, зам талбайн тоосжилт дарах усалгаанд 800.0 м³, уурхайн нөхөн сэргээлтэд нийт 860.0 м³ ус, технологийн усны хэрэгцээнд 139830.3 м³ ус ашиглагдахаар байна. /Ус хэрэглээний нормыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын дагуу баримтлах нормоор тооцов/.
- Ахуйн хогийн цэг болон шингэн хог хаягдлын сав асгарсан тохиолдолд гүний усанд бохирдол үүсэх
- Түлшний савнаас асгаралт үүсэж гүний ус бохирдох
- Бохирын системийн тунгаагч сав, шингээгч худгийг тухайн газар орны хөдөлтийн гүнээс доош газар доор суулгах,
- Бохирын цооног нь тухайн орчиндоо задарч асгарсан тохиолдолд фосфор, азот төрөл бүрийн нянгийн бохирдол үүснэ
- Гүний худгийн ойр орчимд газар доорх усны ариун цэврийн хамгаалалтын бүсийн дүрэм журмыг баримталж ажиллаагүйгээс худгаар дамжин гүний усыг бохирдуулах

Төслөөс хөрсөн бүрхэвч болон ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл:

- Төслийн үргэлжлэх хугацаанд нийт 0.4 га талбайд шимт хөрсийг хуулах бөгөөд шимт хөрс хуулах зузаан дунджаар 20-30 см байна.
- Уурхайн зам талбайн хэмжээ 1.1 га, далд уурхайгаас хөрс болон хүдэр тээвэрлэх зай дотоод тээвэрт жилд дунджаар 0.3 км бөгөөд тээврийн хэрэгслүүд зааж өгсөн маршрутын дагуу явах, олон салаа зам гаргаснаар хөрсний элэгдэл эвдрэл үүсэх
- Уурхайн ажилчдын хотхоны барилга байгууламжийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч эвдрэлд орох
- Ахуйн хог, шингэн хаягдал хаягдсанаас хөрс бохирдох
- Шатахуун түгээх станцын барилгаас үүдэн хөрсөн бүрхэвч элэгдэх

- Тос тослох материалын асгаралтаас үүдэн хөрсний бохирдол үүсэх
- Хөрсний үржил шимт үеийг хуулахад ургамлан нөмрөг устгах
- Тээвэрлэлтээс үүдэн нийт тоосонцорын агууламж 10-40 мкг/м3, РМ10 тоосонцорын агууламж 3-14 мкг/м3 байгаа нь стандарт хэмжээнээс даваагүй бөгөөд олон салаа зам гаргаж явснаар тоосжилт үүсгэж ургамлын фотосинтезийн идэвхитэй туяа шингээлт буурах
- Уурхайн ажилчдын тосгоны барилга байгууламжийн нөлөөгөөр ургамлан нөмрөг устгах
- Уурхайн авто зогсоолыг зориулалтын нэг цэгт хийгээгүйн улмаас ургамлан нөмрөг устгах
- Уурхайн зам талбайн хэмжээ 1.1 га бөгөөд ургамлын ургах орчин муудах, талхлагдах
- Гадаргын нил угаагдал үүсэх, хөрсөн бүрхэвчтэй хамт ургамлан нөмрөг устгах

Төслөөс биологийн төрөл зүйл, түүний амьдрах орчинд үзүүлэх нөлөөлөл:

- Амьтдын амьдрах орчин доройтох, хязгаарлагдах, амьтад карьерт унаж бэртэх
- Амьтдын идэш тэжээлийн орчин хумигдах
- Тээврийн хэрэгслийн дуу чимээнээс амьтад үргэж дайжих
- Шувууд тогонд цохиулах, Амьтдын тоо толгой багасах
- Тэвэрлэлтийн явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурд хэтрүүлэх, санамсар болгоомжгүй үйлдэл гаргаж зэрлэг ан амьтдыг дайрах, гэмтээх

-Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл:

- ✓ Төсөл хэрэгжих талбайн ойр орчинд айл, малын суурьшил байхгүй.
- ✓ Төслийн нөлөөллийн бүсэд төвлөрсөн суурин байхгүй.
- ✓ Уурхайн үйл ажиллагааны үед машин механизмын дуу чимээ, тоосжилтоос хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй.

-Төслөөс нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл:

- Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн, шугам сүлжээний гэмтэл, гал, усны гэнэтийн аюул учирч болзошгүй.
- Төсөл хэрэгжих явцад ажлын байр нэмэгдсэнээр нийгэм, эдийн засгийн хөгжилд тодорхой хэмжээний эерэг нөлөөг үзүүлнэ.
- Орон нутгаас нийлүүлэх боломжтой хүнсний хангамж, ахуйн хангамж, түлш шатахуун нийлүүлэлт зэрэг материаллаг эрэлт үүснэ.
- Орон нутгийн төсөвт НӨАТ, ХАОАТ, АМНАТ, эрүүл мэнд, нийгмийн даатгал, үл хөдлөх хөрөнгийн татвар, өөрөө явагч хэрэгслийн татвар, газар, ус ашигласны төлбөр, хог хаягдлын хураамж зэрэг орлогууд төвлөрнө.

**БҮЛЭГ IV. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

"Ханшашир" ХХК-ийн Дожир хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах арга хэмжээ буюу төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэхэд оршино. "Ханшашир" ХХК-ийн Дожир уурхайн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан БОМТөлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, 2014 оны А-117 тоот тушаалын 4-р хавсралтаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тус тус баримтлан боловсруулж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудсыг хөтөлбөрт хавсаргасан бөгөөд БОМТ-нд

багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний ажил хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, осол эрсдлийн менежмент, хог хаягдлын менежмент, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах зэрэг төлөвлөгөөнүүд багтсан. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд **20 000 000** сая.төг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримтлах арга зүй, стандарт, холбогдох эрх зүйн баримт бичгийн заалт, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, гүний усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичиг, стандартыг тодорхойлох
- Шаардлагатай хөрөнгө, зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох
- Дүйцүүлэн хамгааллаар гүйцэтгэх ажил, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд далд уурхайн орчинд ногоон байгууламж байгуулах ажлыг чанартай хийж гүйцэтгэх зэрэг орно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан болно.

“Ханшашир” ХХК нь 2025 онд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд нийт **48,145,680.5** мян.төгрөгийг зарцуулахаар төлөвлөв. Энд тусгагдаагүй зардлууд нь ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон хөдөлмөр хамгааллын зардалд тусгагдсан болно.

Хүснэгт 3. Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын нэгтгэл

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Хөрөнгийн хэмжээ, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан, газрын хэвлий/	Мян төг	7,310,000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Мян төг	0
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	22,000,000.0
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	0
5	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Мян төг	8,600,000.0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Мян төг	2,872,000.0
7	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	Мян төг	3,363,680.5

8	Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага-зохион байгуулалтын төлөвлөгөө	Мян төг 4,000,000.0
9	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	Мян төг 0
	Дүн	48,145,680.5

БҮЛЭГ V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ханшашир” ХХК-ийн “Дожир нэртэй хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар ашиглах” төслийн уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад төслийн үйл ажиллагаанд технологийн шинэчлэлт болон удирдлага зохион байгуулалтын оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үүсэж болох эрсдэл, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрдүүлнэ. Мөн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартуудыг мөрдөж хэвшүүлж ажиллах нь үүсэх эрсдэл, сөрөг нөлөөллөөс хамгаалах гол үндэслэл болно.

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- ТЭЗҮ, Уулын ажлын төлөвлөлтөөс бусад газрын хөрс, ургамлан нөмрөгийг талхлагдаж доройтохоос сэргийлэх, хамгаалалтын зурвас байгуулах
- ТЭЗҮ-д төлөвлөсний дагуу тоосжилт тархах хүрээг тооцон овоолгын байршлыг ачиж тээвэрлэх, буулгах газраас 50-100 м орчим зайд байршуулах
- Уурхайн замаар зорчих тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах нь тоосжилтыг хянах үр дүнтэй аргуудын нэг юм. Хурдыг 40 км/цаг-с 16 км/цаг болгож бууруулахад замаас үүсэх 10 микроноос бага ширхэглэгтэй тоосонцрын хэмжээ 58%-иар, хурдыг 40 км/цаг-с 24 км/цаг болгоход 42%-иар тус тус буурах боломжтойг судалгаагаар тогтоосон байдаг. Өөр судалгааны дүнд шороон замаар зорчих тээврийн хэрэгслийн хурдыг 40 км/цаг-р хязгаарлахад тоосжилтыг бууруулах үр ашиг нь 44% орчим байна гэж үзжээ. Иймээс тээврийн хэрэгслийн хурдны хязгаарлалтыг дагаж мөрдөх, үүнд ИТА-ын зүгээс хяналт тавих
- Уурхайн дотоод тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг 40 км/цаг-аас бага байлгах, хэт их хурдлах, гэнэт тоормослох зэрэгт дугуйны эргэлтийн хурд нэмэгдэн агаарт үүсэх тоосжилт ихэсдэг, иймээс тээврийн хэрэгслийн хурдыг тогтмол байлгаснаар тоосжилтын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх боломжтой.
- Тээврийн хэрэгслийн замыг засаж сайжруулах, тэмдэгжүүлэх, маршрутын дагуу явуулах үүнд ИТА-ын зүгээс хатуу хяналт тавих
- Тээврийн хэрэгслийн зогсоолыг барьж байгуулах, асфальтаар хучих, тэмдэгжүүлэх
- Тоосжилт, шороон шуурганы давтамж, хуурайшилт ихсэх хаврын улиралд уурхайн дотоод тээвэрлэлтийн авто замыг тоос дарагч бодисоор хучих, өвөл нь автогрейдрээр тэгшлэх, орсон цасыг замын элстэй хольж, тэгшлэн дагтаршуулах
- Ажилчдын эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, уурхайд ажиллах бүх ажилчдыг хувийн хамгаалалтын хэрэгсэл, тусгай зориулалтын хөдөлмөр хамгааллын хувцасаар хангах Тухайлбал: тоос тоосонцор үүсгэдэг, тухайн орчинд ажил гүйцэтгэх үедээ амьсгалын замын эрхтнийг хамгаалах зориулалтын шүүлтүүртэй маск, комбинзон, зэрэг хамгаалах хувцас хэрэгслийг хэрэглэх
- Техник тоног төхөөрөмжийн нэгдсэн үзлэг шалгалт, ашиглагдаж буй машин техникт засвар үйлчилгээг тогтмол хугацаанд чанартай хийх
- Техникийн үзлэгт оруулсан, ялгаруулж буй хорт утаа нь стандарт түвшинд буй машин техникийг ашиглах

- Шимт хөрсийг тээвэрлэхдээ тээврийн хэрэгслийн даацын хэмжээнээс хэтрүүлж ачихгүй байх. Тээврийн хэрэгслийн даацыг хэтрүүлснээр газрын гадаргыг эвдрэлд оруулах, тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа буурах, шатахуун их зарцуулах, дуу чимээ үүсэх зэрэг сөрөг нөлөөллүүд нэмэгддэг. Тиймээс техникийн үзүүлэлтэд заасан хэмжээгээр ачааг тээвэрлэх
- Овоолгын бүтцийг ТЭЗҮ-д тусгасны дагуу төлөвлөж хүчтэй салхи шуурганы үед тоосжилт үүсэхээс сэргийлэх, овоолгыг салхины голлох чиглэлийн доод талд байрлуулах
- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслийн орчны агаарт ялгаруулах ялгаралтыг багасгах үүднээс тэдгээр тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээг тогтмол хийх, чанар сайтай шатах тослох материал, утааны шүүлтүүр ашиглах, утааны хяналтын хэмжилтийг тогтмол хийлгэж байхаас гадна ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгсэл ашиглахгүй байх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх
- Тээврийн хэрэгслийн түлш шатахууны чанарт хяналт тавих
- Уурхайн ажилчид, уурхайд ажиллаж байгаа ажилчдад дуу чимээний бохирдлоос хамгаалах хэрэгсэл, чихэвч зүүлгэх, ашиглаж хэвшүүлэх
- Уурхайн олборлолт дуу шуугианы бохирдолттой нөхцөлд ажилладаг ажилчдад толгой хамгаалах хэрэгсэл-сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл (каска, чихэвч)-ийг зүүлгэж хэвшүүлэх, аюулгүй ажиллагааны дүрэм журманд тусгаж, хэрэгжүүлэх,
- Дуу чимээ цацруулдаг тоног төхөөрөмжид дуу авианы хаалт хийх
- Тоног төхөөрөмж, машин техникт тогтмол хугацаанд үзлэг шалгалт хийх
- Механик ажиллагаатай тоног төхөөрөмжид чичиргээний хамгаалалт суурилуулах
- Дуу чимээний эх үүсвэрийг мэдрэмтгий хүлээн авагчаас холдуулан байршуулах, хамгаалалт хийх

Усны нөөц горимд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- ✓ Ус ашиглах гэрээний дагуу заасан хэмжээнд усыг хэрэглэх, усны хэрэглээг хянах
- ✓ Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.6 заалт, MNS 4219:94 стандартын дагуу төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу экологийн паспорт хөтлөх
- ✓ Усны шинжилгээг тогтмол хугацаанд мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториуд болох Шинжлэх ухааны академи Газарзүй-Геоэкологийн хүрээлэн усны шинжилгээний лаборатори, “ХанЛаб” ХХК усны шинжилгээний лаборатори-уудаас сонгон усны шинжилгээ хийлгэх, мониторинг хийх
- ✓ Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал ил задгай тархсанаас газрын гадарга болон гүний ус бактериологийн бохирдолд орж болзошгүй. Иймээс хог хаягдлын цэгийн эрүүл ахуйн аюулгүй байдал, битүүмжлэлийг хянаж ажиллах
- ✓ Монгол улсын стандарт MNS 5924:2008 “Нүхэн жорлон, угаадасны нүх”-ийн ерөнхий шаардлагын дагуу нүхэн жорлонг барьж байгуулах
- ✓ Үл нэвчих материалаар доторлосон ахуйн болон бохирын шингэн хог хаягдлын цэг байгуулах, ил задгай хатуу, шингэн хог хаяхгүй байх
- ✓ Байгалийн гэнэтийн аюул үер усны үед хөрсөнд угаагдал явагдан түүгээр дамжин гүний усанд бохирдол үүсэхээс хамгаалах, хөрсөнд шатах тослох материал болон бусад бодис алдахаас сэргийлэх, үүнд үйлдвэрийн удирдлага, ажилчид анхаарч ажиллах
- ✓ Уурхайн талбайд үер борооны ус орж ирэхээс хамгаалан 0.5 км урттай хамгаалалтын суваг байгуулах

- ✓ Усны тухай хуулийн 24.4-д зааснаар ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон журмын дагуу ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулна.
- ✓ Усны тухай хуульд заасны дагуу усны эх үүсвэрт энгийн хамгаалалтын бүс 200 м-ээр, онцгой хамгаалалтын бүс 50 м-ээр тогтоох
- ✓ Уурхайд ажиллах ажилтны 1 өдөрт хэрэглэх усны хэмжээг нормын дагуу тогтоож, хэрэгжүүлж ажиллах, ажилчдад усыг хэмнэлттэй хэрэглэх талаар сургалт хийж усны зохистой хэрэглээг бий болгох

Ундны ус, эрүүл ахуйн шаардлага³

- ✓ Ундны ус: Ундны ус нь түүний эх үүсвэр, чанарыг сайжруулах арга, ус хангамжийн тогтолцооны онцлогоос үл хамааран усаар дамжин халдварт болон халдварт бус өвчин тархах аюулгүй, физикийн үзүүлэлт, химийн найрлагаараа зохимжтой, хоргүй, мэдрэгдэх чанар нь харшлахгүй байх нөхцлийг хангасан байна. Усны чанар, аюулгүй байдалд хяналт шинжилгээг мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториор хийлгүүлнэ.
- ✓ Ус хангамжийн эх үүсвэр: Гүний худгийн усны чанар, аюулгүй байдлыг стандартад заасан (MNS 0900:2018, хүснэгт 1-2) үзүүлэлтүүдээр хянаж, усны хими, физикийн шинжилгээний дүн тогтворжсон, стандартын шаардлага хангасан тохиолдолд ашиглана.
- ✓ Ус зөөх тээврийн хэрэгсэл: Ундны усыг зөөвөрлөн түгээх зориулалтаар тоноглогдсон тээврийн хэрэгслийг хэлнэ. Тээврийн хэрэгслийн ус нөөцлөх савнаас дээж авч хяналт шинжилгээг мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториор хийлгүүлнэ.
- ✓ Ундны ус нөөцлөх сав, усны аюулгүй байдал: Ундны усыг нөөцлөх савыг цэвэрлэж, угааж, халдваргүйжүүлсний дараа *E.coli* болон халдваргүйжүүлэх бодисын үлдэгдлийг тодорхойлж, стандартын шаардлага хангасны дараа нийтэд түгээнэ.
 - Усны рН, булингар, *E.coli*, нянгийн тоог улиралд нэг удаа итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлнэ.
 - Хяналт шинжилгээ хийх дээжийг эх үүсвэрийн худаг, ус хадгалах сав, ус түгээх байр, ус зөөх тээврийн хэрэгсэл тус бүрээс авч шинжлүүлнэ.

Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- Шимт хөрсний овоолгыг тайланд тусгасан зөвлөмжийн дагуу, урьдчилан төлөвлөсөн талбайд зонхилох салхины чиглэлийн дагуу нуруулдан гадаргуугийн налууг 18 градусаас ихгүй байхаар налуулан хэлбэршүүлэх,
- Уурхайн ажилчдыг хог хаягдал хаях, ил задгай бие засахгүй байх тал дээр анхааран ажиллаж ариун цэврийн газрыг стандартын дагуу байгуулан ариутгал цэвэрлэгээний ажлыг тогтмол хийх,
- Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж хогийн сав байршуулах /ажилчдын байрны ойролцоо болон дотор орчинд/, Хог хаягдлыг сумын захиргаатай гэрээ байгуулан зөөвөрлөн, зөөвөрлөсний дараа ариутгал хийх,
- Уурхайн тээврийн хэрэгслийн зорчих сайжруулсан зам, талбайг иж бүрэн тэмдэгжүүлэн, тээврийн хэрэгсэл, уулын машин механизмын хөдөлгөөнийг заасан маршрутаар хязгаарлах
- Машин техникийн засвар үйлчилгээг засвар механикийн хэсэг буюу тогтоосон цэгт хийж гүйцэтгэх,
- Машин техникийн шатахуун, тос тосолгоо, шингэний асгаралт шүүрэлтийн хяналтыг тогтмол хийх, тээвэрлэлт хийх хүнд даацын машин механизм техникээс шатахуун, тос тосолгооны материал хөрсөнд гоожиж асгарвал тухайн орчимд цэвэрлэгээг хийх, шатахуун

³ MNS 0900:2018, Ундны усны эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт

- асгаралтыг тухай бүр шуурхай зогсоож арга хэмжээг авах аюулгүй ажиллагааны системийг мөрдөн ажиллах,
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх
 - Техник эдийн засгийн үндэслэл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх
 - Газар шорооны болон барилга байгууламжийн ажлын үед эвдэрсэн газрыг засч тэгшлэх, нөхөн сэргээх
 - Төслийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатайгаас бусад шалтгаанаар газрын гадарга, гадаргуугийн дүр төрхийг өөрчилж, хөндөхгүй байх
 - Уурхайлалтад өртөх газрын хөрсийг 40 см гүнтэй хуулж овоолго үүсгэн стандартын дагуу хадгалах
 - Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулах, хадгалах стандарт MNS5916:2008, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2019 зэрэг бусад хөрс хамгаалах хууль тогтоомжийг баримтлан ажиллах
 - Шимт хөрсний овоолгоор барилга байгууламж барих болон бусад бүтээн байгуулалтын үед талхлагдсан газрыг нөхөн сэргээх, уурхайн хаалт, нөхөн сэргээлтэд ашиглах
 - Уурхайн шимт хөрсний хуулалт хийхдээ 20-30 см зузаантайгаар хуулж, зонхилох салхины чиглэл дагуу нуруулдан, овоолгын гадаргуугийн налууг 18 градусаас ихгүйгээр, хажуугийн налууг 25 градусаас ихгүй байхаар налуулан хэлбэршүүлнэ. Овоолгыг урьдчилан төлөвлөсөн талбайд байршуулах
 - Шимт хөрсний овоолгыг ургамалжуулах
 - Төслийн талбайд машин техник зорчих замыг батлуулах, тогтсон нэг маршрутын дагуу тэвээрлэлт хийх, зорчих
 - Хөрсний бохирдлын мониторингийн цэгүүдийг байгуулж улирал бүр конвертийн аргаар хөрсний өнгөн хэсгээс дээж авч хүнд металл, агрохими болон нянгийн бохирдол зэргийг мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторуудаар тодорхойлуулж хөрсний бохирдлын MNS 3297-2019, MNS 5850:2019 стандартыг баримтлан ажиллах
 - Төслийн үйл ажиллагааны улмаас хөрсөнд элдэв төрлийн бодис алдахгүй байх, ажилчдад орчны бохирдлын талаар зөвлөмж мэдээлэл өгөх
 - Газар хөндөх ажлын хэмжээг ТЭЗҮ-д тусгасны дагуу тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөнд /УАТ/ тусгана. Газар хөндөх, олборлолтын ажлыг эхлүүлэхийн өмнө зохих эрх бүхий этгээд /уурхайн дарга, ашиглалтын инженер/ ажил эхлүүлэх зөвшөөрөл өгч, хэмжилтийн ажлыг гүйцэтгэж, ажил эхлүүлэх улаан шугам татна. Тус ажлыг хэрэгжүүлж ажиллахдаа журам боловсруулж ажиллах
 - Батлагдсан ТЭЗҮ-д тусгасны дагуу уурхай үүсгэх гол үзүүлэлтүүдийг чанд баримтлан ажиллах
 - Уурхайн барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажлыг бүрэн гүйцэтгэж дууссаны дараа барилгын ажлын явцад элэгдэл, эвдрэлд орсон талбайг хэлбэршүүлж, ургамалжуулах
 - Авто бааз, засварын газар орчмын талбайг хатуу хучилт хийж, тос тослох материал хөрсөнд асгарахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай. Сольсон болон бусад тос, тослох материалыг тусгайлсан цэгт, зориулалтын саванд цуглуулах
 - Ахуйн хатуу хог хаягдлыг тусгайлан бэлтгэсэн далан, хашаа хаалт бүхий тогтсон цэгт цуглуулах бөгөөд орон нутгийн захиргаатай хог хаягдлын гэрээ байгуулж, зохих төлбөрийг төлж ажиллах шаардлагатай. Шингэн хаягдлыг бетонон доторлогоотой, тунаах дамжлага бүхий сиптек танканд байршуулж тодорхой хугацаанд задлагч, ариутгагч бодисуудыг хэрэглэх

- Хөрс шингэн хаягдлаар бохирдохоос сэргийлэн 3 шатлал бүхий септик ашиглах бөгөөд сард нэг удаа био ялзмаг хийж задалж байна. Лаг ихээр хуримтлагдсан үед лагийг соруулан авч хамгийн ойр орших цэвэрлэх байгууламжид хүргэх
- Уурхайн хотхон дахь явган хүний замыг тогтсон маршрутын дагуу зохион байгуулж, хатуу хучилт хийх шаардлагатай. Хатуу хучилтад байгалийн чулуу ашиглах
- Уурхайн тосгоны орчимд тогтсон хугацаанд нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах,
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх, эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байх, барилгын ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, тогтоосон авто зогсоол болон зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох болон зорчихыг хориглох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдлыг бууруулах боломжтой ба хэрэгжилтэд уурхайн дарга, байгаль орчны мэргэжилтэн хяналт тавьж ажилах шаардлагатай

Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө эвдэгдэх, хөндөгдөх хөрсийг уулархаг хэсэгт өнгөн хэсгийн 40-50 см, хөндийн хэсэгт 80-95 см зузаантай ялзмагт давхаргыг тусд нь авч хадгалах, биологийн нөхөн сэргээлтэд ашиглах, мониторинг хийх,
- Хөрсөөр дамжин ургамлыг бохирдуулж болзошгүй хог хаягдлыг ангилж ялгах, хөрсөнд алдагдахааргүй хадгалах,
- Хог хаягдлын цэгийг тохижуулах (цемент, төмөр гадаргатай байх), орчиндоо тараахгүй байх талаар арга хэмжээ авах (хашаа хаалт барих) гэх мэт арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Хог хаягдлыг ангилал, шинж чанараас нь хамааран (Шингэн хог хаягдлыг тухай бүрд нь цэвэрлэж зөвшөөрөгдсөн газарт хаях, булах, ариутгах ажлыг тогтмол хийж, гадны нөлөөллөөс тусад нь байлгах, амьтан, ургамал нөлөөлөхөөргүй нөхцөлд байршуулах), (Хатуу хог хаягдлыг хадгалах цэг байгуулан түүнд төвлөрүүлэн хаяж байх, Хатуу хог хаягдлын цэг нь зориулалтын тагтай байх, салхи шуургатай үед хог хаягдал хийсч орчноо бохирдуулахгүй байх ёстой),
- Зам талбайгаар зорчихдоо технологийн зам ашиглах. Тухайлбал: Зам тэмдэг тэмдэглэгээг сайтар байрлуулах, зам ашиглалтад уурхайн зүгээс хатуу хяналт тавих бодлогыг баримтлах нь ургамлан бүрхэвч устах, хөрс эвдрэх эрсдэлээс сэргийлнэ.
- Үйлдвэр орчмын зогсоол, замд машин техникийн шатах тослох материал асгарвал тухай бүрд нь элс, даавуу зэрэгт шингээн авч галын аюулгүй нөхцөлд /төмөр сав зэрэгт хийн шатааж/ ариутгах. Хатуу, шингэн хог хаягдлыг тухай бүрд нь цэвэрлэж зөвшөөрөгдсөн газарт хаях, булах, ариутгах ажлыг хийж байх.
- Төслийн эдэлбэр газраас бусад талбайн ургамлыг хамгаалахын тулд тогтсон нэг маршрутын дагуу явах, хамгаалалтын зурвас байгуулах
- Хуурайшилт ихтэй өдрүүдэд тоосжилт ихээр үүсэхээс хамгаалан зам талбайг услах, тоосжилтоос сэргийлэх
- Ойр орчиндоо ургах ургамал, ургамлын ургалтад хяналт тавьж, бүртгэх, ажиглалт явуулах
- Машин механизм, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол, засвар үйлчилгээний зориулалтын талбай гарган орчны ургамлыг талхлагдахаас сэргийлэх, хэрэгжилтийг уурхайн дарга хариуцан ажиллах, төлөвлөсөн талбайгаас бусад газарт олон салаа зам үүсгэн хөрс эвдрэл оруулах, ургамлыг талхагдуулсан тохиолдолд уурхайн дотоод журмын дагуу хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх
- Машин техникийн шатах тослох материал ойр орчинд асгарвал тухай бүрд нь элс, даавуу зэрэгт шингээн авч галын аюулгүй нөхцөлд /төмөр сав зэрэгт хийн шатааж/ ариутгах. Хатуу, шингэн хог хаягдлыг тухай бүрд нь цэвэрлэж зөвшөөрөгдсөн газарт хаях, булах, ариутгах ажлыг хийж байх, машин техникийн бүрэн бүтэн байдлыг тодорхой цаг хугацаанд шалгах,
- Аливаа газар хөндөлт бүрийн өмнө тухайн талбайн ургамлан нөмрөгийн суурь мэдээллийг цуглуулж, нөхөн сэргээлтийн ажилд тухайн нутгийн ургамлын үрнүүдийг ашиглаж, байгалийн бүлгэмдлүүдийг дахин сэргээх арга хэмжээ авч байх.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж:

- Олборлолтын үед үүссэн илүүдэл нүх, цооног, овоолсон шороо зэргийг тухай бүрт нь булж хуучин байдалд нь оруулан, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг цаг хугацаанд нь чанартай хийж зохих шатны хяналтын байгууллагад хүлээлгэн өгөх
- Уурхайн олборлолт явуулах бүсийн ойролцоо амьтдын орогнох нүх үүр эвдэгдэх, ойролцоох малчин айлын мал амьтан уурхайн талбайн ухаш нүхэнд унаж үрэгдэхээс сэргийлж уурхайн талбайг хашаалах
- Уурхайгаас олборлолт явуулах үед үүсэх аманд хаалт хашлага хийж мал амьтад унаж үрэгдэхээс сэргийлэх, үйл ажиллагаа дууссаны дараа үүссэн нүх, ухашуудыг дүүргэлт хийн техникийн нөхөн сэргээлтийг Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008, Эвдэрсэн газрын хажуугийн налуу техникийн шаардлага MNS 4920:2000, Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах ерөнхий шаардлага MNS 0017-5-1-19-92, Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 4918:2000-ын дагуу нөхөн сэргээж, сум орон нутагт хүлээлгэн өгөх
- Нефть, нефтийн бүтээгдэхүүн болон бусад хортой бодис асгарах, гоожих тохиолдолд орчны хөрсөн бүрхэвч, усан орчин, ургамлан нөмрөг, хөрсөн дэх микроорганизмууд хөнөөгдөх аюултай учир хяналт үзлэг үйлчилгээг өдөр тутам хийж, аюулгүй ажиллагааг хэрэгжүүлэн ажиллах
- Амьтдын идэш тэжээл эрж хайх, нүүдэллэх зам харгуй, нүх оромжийг мэргэжлийн шинжээчийн тусламжтайгаар судалгаа хийн тогтоож анхааруулсан тэмдэгүүд байрлуулах, тогтоосон маршрутын дагуу тээврийн хэрэгслийг явуулах
- Уурхайн ажилчдад төсөлд тусгасан зам, маршрутаас бусад газраар машин техникийн хэрэгслээр явж ойр орчны амьтдыг үргээхгүй байх, зэрлэг ан амьтдыг агнахыг хориглох анхааруулга, сануулга өгч байх, ан амьтан агнасан тохиолдолд хариуцлага тооцох
- Төслийн талбайн ойр орчмын ан амьтдын тоо толгойн өөрчлөлтийг хянаж, ажиглалт, мониторинг хийх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Өвөлжилт хүндэрсэн үед ойролцоох тусгай хамгаалалттай газар нутгийн зэрлэг ан амьтан болон малчдад өвс тэжээлийн тусламж үзүүлэх, зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэрэг орчны ан амьтдыг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Уурхайн ажилчдад “Амьтны тухай” хуулинд заасны дагуу өвчилсөн, байгалийн гамшиг болон бусад аюулд нэрвэгдсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах талаар мэдээлэл өгч амьтдад энэрэнгүй хандах дадал зуршлыг бий болгох
- Хөрсөн орчны бохирдол ихэссэн тохиолдолд хөрсөнд агуулагдах бичил биетнүүд халдварт өвчин үүсгэх зэрэг сөрөг нөлөөлөл гарахаас урьдчилан сэргийлж ариутгалыг ариун цэврийн цэг болон хогийн цэгийн орчинд хийлгэх
- Шувууд цахилгааны утсанд цохиулхаас сэргийлэн шувуу үргээгч төхөөрөмжүүд байрлуулах

Нүүлгэн шилжүүлэх, нутгийн иргэдэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж

- Уурхайн жил бүрийн түр хаалтын ажлыг “Газрын хэвлийн тухай хууль”-д заасны дагуу “Газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож, улс ардын аж ахуйн хэрэгцээнд цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулан хүлээлгэн өгөх” ажлыг онцгойлон анхаарч хэрэгжүүлэх
- Уурхайг түр болон бүрмөсөн хаах үедээ уурхайн мөргөцгөөс хүн, мал унахаас хамгаалж уурхайн дээд мөргөцгөөс 5 м-ийн зайд 2.5 метрээс доошгүй өндөртэй шороон далан эсвэл хашлага барих
- Орон нутгийн захиргаатай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хамтран ажиллах

- Гэнэтийн аюул осол тохиолдсон үед яаралтай тусламж үзүүлэх, өвөлжилт хүндэрсэн үед нутгийн иргэдэд өвс, хадлангийн тусламж үзүүлэх зэргээр орон нутгийн иргэдэд боломжит тусламж үйлчилгээг үзүүлэх
- Ойр орчимд оршин суугаа малчин иргэдэд уурхайн олборлолтын бүс тодорхой харагдахуйц байхаар тэмдэг тэмдэглэгээг хийх
- Орон нутгийн болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад уурхайн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөллүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнах
- Орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжин ажиллах /сүү, мах, хоол хүнсний зүйлсийг орон нутгийн иргэд, малчдаас авах/
- Иргэдийн ундны усанд сөрөг нөлөөлөл учрахаас сэргийлэн уурхайн ойролцоох унд ахуйн хэрэглэнд ашиглагддаг гүний худгуудаас дээж авч шинжилгээ тогтмол хийлгэж байх
- Төслийн үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг хамруулах

Түүх, соёлын дурсгалт зүйлт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж:

- Төслийн хэрэгжилтийн явцад ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомж буюу МУ-ын Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Уулбаян сумын засаг захиргааны байгууллага, ШУА-ийн Түүхийн хүрээлэнд /ШУА-Түүх, археологийн хүрээлэн Утас:11458305/ даруй мэдэгдэх, хамгаалах ажлыг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор гүйцэтгэх шаардлагатай
- Соёлын өвийг хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, үүнд ИТА, уурхайн дарга хяналт тавин ажиллах
- Түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд зар сурталчилгааны самбар, бичиг хадах, анхны хэлбэр төрх, хийц, бүтцийг өөрчлөхийг хориглох, ажилчид албан хаагчдад энэ талаар мэдээлэл өгөх

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж

- Байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ БОНБНУ-ний тайлан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын талаар уурхайн бүхий л түвшний инженер албан хаагчдад жил бүр уурхай эхлэхээс өмнө болон тодорхой хугацаагаар (сард нэг удаа) байгаль орчны мэргэжилтэн, байцаагчдыг оролцуулсан сургалт семинар зохион байгуулж байх
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлэх,
- Төсөл хэрэгжүүлэгч нь захирлын тушаалаар Байгаль орчны мэргэжилтэн, ХАБЭА-н ажилтан томилсон байх,
- Ажлын байрны онцлогт нийцсэн аюулгүй ажиллагааны дүрэм, журам, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээг эрсдэлийн үнэлгээ хийн түүнд үндэслэн боловсруулж мөрдөх нь нийтлэг дүрэм журмаар зохицуулснаас илүү үр өгөөжтэй байх давуу талтай,
- Уурхайн ажлын байрны аюултай хортой хүчин зүйлийн нөлөөллийг арилгах, бууруулах, сайжруулахад шаардагдах мөнгөн хөрөнгийг компанийн санхүүгийн төсөв тооцоонд тусган оруулж төлөвлөх,
- Ажилчдад олгох ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгсэл нь стандартын шаардлага хангасан аюултай хортой хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалж чадахуйц байх
- Аливаа газар шорооны ажил эхлэхийн өмнө үндсэн болон гэрээт гүйцэтгэгч байгууллага Байгаль орчны багаас “Газар хөндөх зөвшөөрөл” авсан байх

- Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах
- Уурхайн дотоод тээвэрлэлтэд машин техникийн хурдыг 30 км/цаг-аас илүүгүй байлгах бөгөөд энэ хязгаарын доторх хурдыг уурхайн тухайн нөхцөлтэй уялдуулан тогтоож мөрдөнө. Шатах тослох материал тээвэрлэх машины хурдыг 10 км/цаг-аас хэтрүүлэхгүй байх, үүнд уурхайн дарга хяналт тавьж ажиллах
- “Дожир” хайлуур жоншны ордын олборлолт машин техникийн тээвэрлэлтээс үүдэн байгаль орчинд сөрөг нөлөө учруулахаас сэргийлэн Монгол улсын Авто замын тухай хуулийн 9.1.8 болон засгийн газрын 379-р тогтоол, “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын дагуу тусгай зөвшөөрлийн талбай доторх технологийн замыг засаж сайжруулах, тэмдэгжүүлэх
- Уурхай орчим, доторх зам талбайгаар зорчихдоо технологийн зам ашиглах. Мөн Замын тэмдэг тэмдэглэгээг Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага, MNS 4597:2013 стандартын дагуу сайтар байрлуулах, зам ашиглалтад уурхайн зүгээс хатуу хяналт тавих,
- Уурхайн олборлолтын ажлыг ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу уурхайн тоног төхөөрөмж, ажиллах хүн хүчний нөөцөд тулгуурлан тодорхой хуваарийн дагуу явуулах
- Тус уурхайд осол аваар гарах гол хүчин зүйлс нь уурхайн хүнд оврын машин техник хэрэгсэл бөгөөд эдгээрийн ажиллуулах оператор, инженер техникийн ажилтнууд мэргэжлийн түвшинд мэргэшсэн байх
- Орон нутгийн болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад уурхайн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй сөрөг нөлөөллүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнах
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайн гүйцэтгэлтэй ажиллахын зэрэгцээ хаалтын жилүүдэд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох хууль журам, стандартын дагуу хийж орон нутгийн байгууллагад хүлээлгэн өгөх
- Төсөл хэрэгжих явцад 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар тухайн уурхайн эдэлбэр газарт Газрын төлөв байдал улсын чанарын хянан баталгаа хийлгэх
- Байгаль орчны аудитыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10.1 зүйлд заасны дагуу “Байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ” төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг хийлгэх, цаашид төслийн 2 жил тутамд аудитыг хийлгэх,
- Байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгч 2 жил тутамд байгаль орчны хуваарьт аудит хийлгэн, аудитын тайлан болон аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны газарт ирүүлж, уг аудитын тайлан, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланд менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн талаар бодит мэдээлэл, дүгнэлтийг тусгасан байх
- Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааг 5 жилд 1 удаа мэргэжлийн байгууллагаар хийлгэх
- Жил бүр ажлын төлөвлөгөөндөө орчны хяналт шинжилгээний зардлыг тусган хэрэгжүүлж байх
- Хагас жил бүр орчны хяналт, шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, шинжилгээний үзүүлэлтийг анхааралтай судалж өөрчлөлтийн үндсэн шалтгааныг тодорхойлон цаашид байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулах хэрэгтэй.

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
"ХАНШАШИР" ХХК

- Уурхайн үйл ажиллагааны явцад гарсан хоёрдогч түүхий эдийн хог хаягдлыг ангилан ялган тусгай цэгт цуглуулж, төвлөрсөн цэгт тушаах, ШТМ-ын хаягдлыг хуримтлуулан хаягдал авах газарт (Алтан оршихуй ХХК, 99104569) хүргүүлэх, гэрээ хийн хамтран ажиллах
- Авто бааз, засварын газар орчмын талбайг хатуу хучилт хийж, шатах тослох материал хөрсөнд асгарахаас урьдчилан сэргийлэх
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж БОАЖЯ-аар батлуулан ажиллах

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
"ХАНШАШИР" ХХК

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжигдэхүүн	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
АГААРЫН ЧАНАР								
Уурхайн барилга байгууламж, олборлолт	1.Уурхайн кемп, далд уурхайн барилга байгууламжийн төлөвлөлтийн явцад шимт хөрс хуулалтаас агаар орчинд тоосжилт үүсэхээс сэргийлэн тоос дарагч бодис цацах	Уурхайн кемп, далд уурхайн байгууламж	1удаа	500000	1	-	Хавар, намрын хуурашилт ихтэй үед 1 удаа	-Замын тэмдэг, техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2003 -Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 7-р зүйл -MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ, техникийн ерөнхий шаардлага -Бензин хөдөлгүүрт автомашин MNS 5013:2003 -Дизель хөдөлгүүртэй MNS 5014:2003
	2.Уурхайн олборлолтоос гарах хүдрийг тээвэрлэх тээврийн үямаас тоосжилт үүсэхээс сэргийлэн тоос дарагч бодис цацах	Уурхайн дотоод тээврийн зам	1удаа	500000	1	-	1 удаа	
Тээвэрлэлт, хүнд даацын машин механизмын нөлөөгөөр тоосжилт үүсэх	3.Уурхайн талбайн гадна талд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хурдны хязгаарлалтыг 40-50 км/цаг, уурхайн дотоод зам талбайд 10-20 км/цаг-аар мөрдүүлэн ажиллах, хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулах /уруу, налуу, уулзвар, замын чиглэл заасан г.м/	Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам	ш	110000	4	440000	7 сард 1 удаа	
Машин механизмаас ялгарах хорт хий агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	4.Ашиглагдаж буй тээврийн хэрэгслээс ялгарах хорт хийг стандартын түвшинд байлгах, стандартаас давсан тохиолдолд агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн төлбөрийг төлөх	Уурхайн дотоод болон гадаад тээврийн замд ашиглах тээврийн хэрэгслүүд	удаа	ҮАЗ-д	-	-	1 удаа	
Нийт мян.төг						1 440 000		
ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ								
Усны нөөц багасах, бохирдох	1.Уурхайн ус ашиглуулах гэрээ байгуулах, хэрэглээнээс хамаарч ус ашигласны төлбөр төлөх	Усны эх үүсвэр	удаа	650000	1	650000	Уурхайн үйл ажиллагааны туршид	-Усны тухай хуулийн 28-р зүйл, 30-р зүйлийн 30.6 дахь заалт

**ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
"ХАНШАШИР" ХХК**

	2. Ундны эх үүсвэрийг тоолууржуулж тогтмол бүртгэл хөтлөх	Усны эх үүсвэр	удаа	ҮАЗ-д	-	-	Уурхайн үйл ажиллагааны турш	-Эрүүл ахуйн тухай хуулийн 4-р зүйл -Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 -Хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт хийх журам
	3. Уурхайн гүний худгийн эх ундрагыг хамгаалах, хашаа хайс хийх /Хамгаалалтын бүсийг хийхдээ мал ундаалах эх үүсвэрийг гаргаж өгөх, эрүүл ахуйн бүс энгийн 200м, онцгой бүс 50м/	Усны нөөц горимд үзүүлэх нөлөөллийн бүс	1 удаа	1000000	1	1000000	Уурхайн ашиглалтын хугацаанд 1 удаа	
Нийт мян.төг						1 650 000		
ГАЗРЫН ХЭВЛИЙ, ХӨРСӨН БҮРХЭВЧ								
Уурхайн үйл ажиллагааны явцад хөрсний элэгдэл эвдрэл нэмэгдэх, доройтох, талхлагдах	Уурхайн олборлолт, хөрсний гадаад овоолго, барилга байгууламжид өртөх талбайн үржил шимт хөрсийг зонхилох салхины чиглэлийн дагуу өндөр нь 5м-ээс илүүгүй овоолж, өнгөн хэсгийг ургамалжуулах	Уурхайн кемп, засварын цех, зогсоол, далд уурхайн байгууламжууд	удаа	ҮАЗ-д	1	-	Үйл ажиллагааны турш	-Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008
Уурхайн олборлолтоос гарсан хүдрийг тээвэрлэх явцад агаар орчинд тоомжилт үүсэх, явган замыг сайжруулаагүй тохиолдолд хөрсөн бүрхэвч элэгдэж эвдрэлд орох	Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хязгаарлах, тогтсон маршрутын дагуу явуулах үүнд ИТА-ын зүгээс хяналт тавьж ажиллах	Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам	-	ҮАЗ-д	-	-	Олборлолтын үйл ажиллагааны турш	-Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7-р зүйлийн 2.5 дахь заалт
	Төслийн объектууд хоорондын явган хүний замыг засаж сайжруулах	Зам талбай	-	ҮАЗ-д	Олборлолтоос гарах хайрга чулууг ашиглах			-Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 25-р зүйлийн 1.2 дахь заалт
Хог хаягдал болон техникийн шатах, тослох материалаар хөрсөн бүрхэвч бохирдох	Машин техникийн засвар үйлчилгээг ТЭЗҮ-д заасан цэгт байгуулах, засвар хийгдэх талбай болон авто зогсоолыг хатуу хучилттай болгох Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг мөрдөн ажиллах, нефт, нефтийн бүтээгдэхүүн асгарсан тохиолдолд саармагжуулах хэрэгслийг	Засварын газар, авто зогсоол	удаа	ҮАЗ-д	1	-	8 сард 1 удаа	-Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019

	байршуулах, бүрэн бүтэн байдлыг хянах							
Уурхайн кемп, далд уурхай, овоолго болон уурхайн үйл ажиллагаанаас газрын хэлбэр, төрхөд өөрчлөлт орох	Төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан зураг төсөл, уулын ажлын төлөвлөгөө, техник ашиглалтын журмын дагуу газрын хэвлийг ашиглах	Төслийн хүрээнд	-	ҮАЗ-д	-	-	Уурхайн үйл ажиллагааны туршид	-Газрын хэвлийн тухай хуулийн 31-р зүйлийн 1 дэх заалт
	Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээний биелэлтийг хангах үүнд ИТА-д хяналт тавих, хариуцан ажиллах	Төслийн хүрээнд	-	ҮАЗ-д	--		Уурхайн үйл ажиллагааны туршид	-Газрын хэвлийн тухай хуулийн 32-р зүйлийн 8 дахь заалт
	Нийт дүн					00		
УРГАМЛАН НӨМРӨГ								
Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлөх	“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тариалах	Төслийн хүрээнд	ш	5000	500	2500000	10 сард	-Байгалийн ургамлын тухай хуулийн 7-р зүйлийн 1 дэх заалт
	Тарьсан модны арчилгаа, усалгааг хийж гүйцэтгэх, ургалтын хувийг нэмэгдүүлэх	Төслийн хүрээнд	удаа	-	10	-	5-10 сар	
Уурхайн автомашины хөдөлгөөн, тээвэрлэлтээс ургамлан нөмрөг талхлагдах	Төслийн эдэлээр газраас бусад талбайн ургамлыг хамгаалах зорилгоор ажилчид болон машин техникийн хөдөлгөөнийг тогтсон маршрутын дагуу явуулах, хамгаалалтын зурвас тогтоох	Төслийн талбай	1 удаа	ҮАЗ-д	-	-	Үйл ажиллагааны туршид	-Газрын тухай хуулийн 50-р зүйлийн 1.4 дэх заалт
	Нийт дүн:					2500000		
АМЬТНЫ АЙМАГ								
Амьтдын амьдрах орчин доройтох, хязгаарлагдах	Уурхайн олборлолт явуулах үед үүсэх далд уурхайн ам, ухаш нүхэнд хаалт хашлага хийж, мал амьтан унаж үрэгдэхээс сэргийлэх	Далд уурхайн ам, ухаш	50м	1500000	1	1500000	9 сард 1 удаа	-Амьтны тухай хуулийн 6-р зүйлийн 1.2 дахь заалт
	Уурхайн ашиглалтын талбайн хамгаалалтын даланг сэргээх, хашаа хайсыг барьж дуусгах, бүрэн бүтэн байдлыг хянаж, мал, амьтан	Уурхайн кемп, далд уурхай, тээврийн зам	ш	110000	2	220000	8 сард 1 удаа	

	орохоос сэргийлэх, тэмдэг тэмдэглэгээ байршуулах							
	Орон нутгийн болон аймгийн байгаль орчны газрын хэрэгжүүлж буй амьтан хамгаалах арга хэмжээнд оролцож хамтран ажиллах	Төслийн хүрээнд	удаа	ҮАЗ-д	-	-	Ирүүлсэн санал хүсэлтийн дагуу	
	Хууль бусаар амьтан агнах, ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох арга хэмжээн дээр хяналт тавих	Төслийн хүрээнд	удаа	ҮАЗ-д	-	-	9 сард БОМ	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 19-р зүйлийн 2.1 дэх заалт
Нийт дүн						1720000		
НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ /ТӨГ/					7,310,000.00			

БҮЛЭГ VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Байгаль орчин, геологи уул уурхайн хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад хууль, тогтоомж, зааврын дагуу уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага Монгол улсын стандартын дагуу зайлшгүй хийсэн байх үүрэгтэй. Тус уурхай нь далд уурхайгаар үйл ажиллагаа явуулдаг тул 2025 оны Уулын ажлын ашиглалтын төлөвлөгөөнд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй.

БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ”-нд тусгах ажлын саналыг Хэнтий аймгийн БО-ны газрын саналыг үндэслэн тухайн газартай экологийн хувьд төстэй тус сумын нутаг дэвсгэрт дүйцүүлэн хамгаалах газар нутгийг сонгон хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8

1	Биологийн олон янз байдлын суурь судалгаа хийх, хамгаалах арга хэмжээ авах	Хэнтий аймгийн БОАЖ-ын газраас ирүүлсэн саналын дагуу дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж гүйцэтгэх	-	-	-	-	Санал ирүүлсэн хугацаанд	-Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэх гарын авлага -БОНБНҮ-ий тухай хуулийн 3.1.11, 8.4.6, 9.6 зүйл, -Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт -БОНХ-ийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10- ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан БОНБНҮ-ний аргачлалын 3.3.6
Нийт зардал /төг/							22,000,000.00	

БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийн уурхайлалтын бүс болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагааны зориулалтаар ашиглагдах барилга байгууламж барих явцад уурхайн ашиглалтын талбайгаас түүх, соёлын дурсгалт олдворууд илрээгүй боловч төслийн үйл ажиллагааны үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоон энэ тухай орон нутгийн Засаг дарга, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

БҮЛЭГ X. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн боловсруулалтын үйл ажиллагаанд химийн бодисыг ашигладаг тул химийн бодисоос эрсдэл үүснэ. Гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгалаа.

Хүснэгт 6. Болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
Ажлын байранд гарч болзошгүй гэнэтийн осол аваар	Ажилчдын амь насанд учруулж болох осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бүх ажилчдыг хамгаалалтын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Далд уурхайн бүх ажилчид	40ш	150000	6000000	Хавар намрын улиралд 1 удаа	-Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль

	ХАБЭА-н дүрэм, замын хөдөлгөөний дүрэм, галын аюулаас хамгаалах төлөвлөгөөг ажилчдад танилцуулж, ажил эхлэхээс өмнө аюулгүй ажлын зааварчилгаатай танилцуулах	Далд уурхайн бүх ажилчид	1	ҮАЗ-д	-	6 сард 1 удаа	-Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хамгаалалтын хувцас-ерөнхий шаардлага MNS ISO 13688:200
	Ажилчин бүр ажил эхлэхийн өмнө ажлын байр, машин, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, ажилд хэрэглэгдэж багаж хэрэгсэл, дохиолол, холбоо, гэрэлтүүлэг, хамгаалах хэрэгсэл тоноглолын гэмтэлтэй эсэхийг шалгах	Далд уурхайн бүх ажилчид				7 сард 1 удаа	
	Эмнэлгийн анхан шатны тусламжийн хайрцагт байх эм, хэрэгсэл материалуудаар хангах	Төслийн хүрээнд	1 удаа	600000	600000	9 сард 1 удаа	
	Бүх барилга байгууламжийн доторх цахилгаан тоног төхөөрөмж гэрэлтүүлгийн угсралт монтажийг шаардагдах стандартын дагуу хийж, тогтмол үзлэг шалгалт хийх	Далд уурхайн бүх ажилчид	1	ҮАЗ-д	-	6 сард 1 удаа	
Төслийн талбайд гарч болзошгүй гэнэтийн осол аваар	Төслийн талбайд үйл ажиллагаанаас үүдэн ШТМ, хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээ, химийн бодис хадгалалт ашиглалт зэргээс газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд асгаралт үүсч бохирдуулсан тохиолдолд асгаралтын иж бүрдлийн ашиглалтын бэлтгэлийг хангах	Уурхайн кемп, далд уурхай, засварын цех, авто зогсоол	1 удаа	400000	400000	Аюул үүссэн үед	-Галын аюулгүй байдлын тухай хууль
	Шингэн хаягдлыг бетонон доторлогоотой, тунаах дамжлага бүхий сиптек танканд байршуулж тодорхой хугацаанд задлагч, ариутгагчаар ариутгах, агаар орчинд эвгүй үнэр тархахаас сэргийлэх	Уурхайн кемп /гал тогоо/	2 удаа	200000	400000	6, 8 сард	
Хээрийн болон объектын гал түймэр	Хээрийн болон объектийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж сургалт зохион байгуулах, галаас хамгаалсан зурвас татах, болзошгүй аюул осол тохиолдоход гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг бэлэн байлгах, нөхөн бүрдүүлэлт хийх	Төслийн хүрээнд	1 иж бүрдэл	1200000	1200000	9 сард 1 удаа	
Үер усны аюул	Гэнэтийн үер усны аюулаас урьдчилан сэргийлэн үерийн далан хийж суваг шуудуу татах	Төслийн хүрээнд	-	ҮАЗ-д	-	8 сард 1 удаа	

Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийг ШТС болон ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газарт суурилуулах, цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг стандартын дагуу газардуулсан байх, холбогдох байгууллагаар ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулах	Төслийн хүрээнд	удаа	ҮАЗ-д	-	6 сард 1 удаа	
Нийт төсөв /төг/					8,600,000.0		

БҮЛЭГ XI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалт

Хог хаягдлаа хэрхэн бага ялгаруулах, ангилах, ялгах талаар сургалтыг ажилчдад байгуулна. Уг уурхай нь 80 ажилчидтай байх бөгөөд нэг ажилчнаас хоногт дунджаар 0.3 кг ахуйн хатуу хог хаягдал гарна гэж үзвэл хоногт 24.0 кг, жилд 5.0 тн нийт хаягдал гарна. Уурхайгаас гарах хаягдлыг ангилж ахуйн хогтой хамт түр хадгалах ба орон нутгийн Захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний дагуу тээвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.

Уурхайн ашиглалтын ажлын үед ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжүүдэд зохих хуваарийн дагуу техникийн үйлчилгээ хийх үед ажилласан тос, тосолгооны хаягдал материал гарахаар байна.

Уурхайн суурингаас гарах ахуйн зориулалтаар хэрэглэсэн бохир ус, шингэн хаягдал орчныг бохирдуулах нөлөөтэй.

Хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах арга хэлбэр:

Уурхайн гаралтай металл хаягдлыг тусгай талбайд хурааж, тээвэрлэж, 2-догч түүхий эд болгон борлуулах арга хэмжээг авна.

Мөн ажиллагсдын байрлах байрнаас хатуу хог хаягдал гарна. Үүнийгээ гэрээ байгуулан тогтмол хугацаанд хогийн цэгт тээвэрлүүлж, гарсан зардлыг бүрэн барагдуулж ажиллана.

Шингэн хаягдал цэвэрлэгээ, арга хэлбэр, зайлуулалт:

Ахуйн шингэн хаягдлыг тусгай бэлтгэсэн нүхэнд хаяхын зэрэгцээ бие засах газрыг эрүүл ахуйн талаас нь стандартын шаардлага хангахуйц бетонон доторлогоо хийх, засаж тохижуулж үнэр болон бусад сөрөг нөлөөлөл үүсэхээс урьдчилан сэргийлж байгуулах болно.

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
1.Ахуйн хог хаягдал								
Цаасны хаягдал	Оффисоос гарч буй цаасны хаягдлыг / бүх төрлийн цаасан хайрцаг, бусад/ зориулалтын хогны уутанд ангилан хаях	Уурхайн оффис	удаа	ҮАЗ-д	-	-	Хуримтлал үүсэх бүрт	-Хог хаягдлын тухай хуулийн 10-р зүйл

Хүнсний хаягдал	Уурхайн кемпийн гал тогооноос үүсч буй хүнсний хог хаягдлыг ангилан ялгах	Уурхайн гал тогоо	удаа	ҮАЗ-д	-	-	Хуримтлал үүсэх бүрт	
Хуванцар хаягдал	Уурхайн кемпээс үүсэж болох хуванцар сав баглаа боодлыг (цэвэр ус, ундаа, хоолны хуванцар сав ундааны лааз, тугалган сав гэх мэт) зориулалтын газарт цуглуулж, эргүүлэн ашиглах шаардлагатай газарт нийлүүлэх	Уурхайн кемп	удаа	ҮАЗ-д	Тухай бүр	-	Хуримтлал үүсэх бүрт	
Бусад	Хатуу хог хаягдлыг хөрсөнд элдэв шингэн нэвчиж бохирдуулахааргүй, салхинд хийсч орчныг бохирдуулахааргүй тусгайлсан төмөр торон хашлагад байршуулах, хатуу хаягдал цуглуулах байгууламж хийх	Төслийн талбай орчим	удаа	600000	1	600000	8 сард	
	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж хогийн сав байршуулах /ажилчдын байрны ойролцоо болон дотор орчинд/	Төслийн талбайн орчим	ш	40000	3	120000	8 сард	
	Дахин боловсруулагдахгүй бусад хаягдлыг /хоолны хаягдал, 00-ын цаас гэх мэт.../ зориулалтын хогийн цэгт хаях	Төслийн талбайн орчим	удаа	ҮАЗ-д	Тухай бүр	-	Хуримтлал үүсэх бүрт	
2.Үйлдвэрийн хог хаягдал								
Төмрийн хаягдал	Төмрийн хаягдлыг хоёрдогч түүхий эд авах цэгт нийлүүлэх	Төслийн талбайн орчим	-	ҮАЗ-д	-	-	Хуримтлал үүсэх бүрт	
Модны хаягдал	Модны хаягдлыг ахуйн түлшинд хэрэглэх	Төслийн талбайн орчим	-	ҮАЗ-д	-	-	Хуримтлал үүсэх бүрт	
3.Аюултай хог хаягдал								
Аюултай хог хаягдал	Уурхайн үйл ажиллагааны явцад гарсан хоёрдогч түүхий эдийн хог хаягдлыг ангилан ялган тусгай цэгт цуглуулж, төвлөрсөн цэгт тушаах, ШТМ-ын хаягдлыг хуримтлуулан хаягдал авах газарт хүргүүлэх, гэрээ хийн хамтран ажиллах	Төслийн талбай орчим	-	ҮАЗ-д	-	-	Хуримтлал үүсэх бүрт	Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг
	Аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг /гутал, химийн бодист тэсвэртэй хамгаалалтын хувцас, малгай, нүдний шил, бээлий, нүүрний баг, амьсгал	Төслийн талбай орчим	ш	500000	1 иж бүрдэл	500000	6 сард	

	хамгаалах/ шаардлагатай газар байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангах							
	Хог хаягдлын цэгийг тогтмол ариутгаж байх	Төслийн талбай орчим	удаа	192000	2	384000	6, 8 сард	
	Нийтийн цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа зохион байгуулах	Төслийн талбай орчим	удаа	-	ҮАЗ-д	-	10 удаа	
	Хог хаягдлын цэгийг төвлөрсөн нэг цэгт байгуулж, хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу сар тутамд зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаях	Төслийн талбай	удаа	634000	2	1268000	7, 9 сард	
Нийт төсөв /мян.төг/						2,872,000.0		

БҮЛЭГ XII. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Ханшашир” ХХК -иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм. “Ханшашир” ХХК -ийн Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт орших Дожир далд уурхайн төслийг хэрэгжүүлэхэд дээрх аргачлалын дагуу “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” -ийг явуулах үүрэгтэй бөгөөд гаргах зардлыг тус компани нь бүрэн хариуцна. Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ-н харьяа БОХЛ, “ХАНЛАБ” ХХК-ийн итгэмжлэгдсэн лаборатори, Геологийн төв лаборатори, Газарзүйн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори болон УСУГ-ын усны лабораторид мөрдөгдөж буй үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал (төг)	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанар								

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
"ХАНШАШИР" ХХК

1	Агаар орчны шинжилгээг мэргэжлийн байгууллагын шинжээчээр хийлгэх	Агаар бохирдуулагч бодисын хэмжээ: -Нүүрстөрөгчийн исэл CO -Азотын исэл (NO ₂) -Хүхрийн давхар исэл (SO ₂) -Дуу чимээ Дба -Нийт тоос TSP -Уурхайн хотхон -Уурхайн ам	5, 9 сард	2	130 500	2 цэг х 130500 = 261 000x2 522000	-MNS 6063:2010 Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS 4585:2016 Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага,
2	Уурхайн ажилчдын хотхоны доторх агаар дахь бохирдуулах бодис, физик нөлөөллийн хэмжилт	Температур, агаарын урсгалын хурд, харьцангуй чийглэг, нүүрсхүчлийн хий CO ₂ , гэрэлтүүлэг -Уурхайн хотхон	5, 9 сард	2	-	271680.5	
Нийт зардал /төг/						793680.5	
Хөрсний бохирдол							
3	Хөрсний хими физикийн шинж чанар -Хөрсний төлөв байдал -хөрсний үе давхрагын зузаан см -элэгдэл эвдэрлийн нөхцөл	-уурхайн хотхон -шимт хөрсний овоолго -нөлөөлөлд өртөөгүй талбай -Ялзмаг %, pH, CaCO ₃ , EC _{2.5} , хөдөлгөөнд фосфор, кали -Механик бүрэлдэхүүн, эзэлхүүн, жин -Хүнд металлын шинжилгээ ME-ICP41	хээрийн судалгааны үед хэмжилтээр тодорхойлох 5, 9 сард 5, 9 сард	2 2	120 000	Томилолтын зардал 270000 3 цэгт х 2 360000 3 цэг х 2 360000	MNS 3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Нийт /төг/						990 000	
Усны хяналт шинжилгээ							

**ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
"ХАНШАШИР" ХХК**

1	Усан дахь эрдэс бодисууд, химийн найрлага	-Ажилчдын гал тогоо / гүний худаг (Анионууд: Cl ⁻ , SO ₄ ⁻ , NO ₂ ⁻ , NO ₃ ⁻ , CO ₃ ⁻ , HCO ₃ ⁻ Катионууд: Na ⁺⁺ K ⁺ , Ca ⁺⁺ , Mg ⁺⁺ , NH ₄ ⁺ , Fe ⁺⁺ , Fe ⁺⁺⁺ , pH, EC, TDS, Физик чанар: тунгалаг, үнэр, тунадас, өнгө, амт)	5, 9 сард	1 удаа	240000	1 цэг 240000		MNS 4943:2008 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир усны ерөнхий шаардлага MNS 6148:2010 Газар доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 0900:2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага чанар аюулгүй байдлын үнэлгээ
	Усан дахь нян бактерийн шинжилгээ	Унд ахуйн худаг 47°44' 16'' 111°47'13''	7, 9 сард	1 удаа	240000	1 цэг 240000	Унд ахжйн усанд химийн болон бактерлогийн бүрэн шинжилгээ хийлгэхэд жилд 2 удаа	
		Нийт	480,000.0					
			Ургамлан нөмрөг					
	Ургамлын зүйлийн бүрдэл, тусгаг бүрхэц, арвийн үнэлгээ	-уурхайн хотхон -хөрсний овоолго -нөлөөлөлд өртөөгүй талбай	7-р Уурхайн Байгаль орчны мэргэжилтэн хээрийн судалгааг хийж гүйцэтгэх 500000					-Монгол орны хэмжээнд ургамлан нөмрөгийн талхлагдлыг тодорхойлох MNS5546:2005 -Ургамлын хээрийн судалгааны арга зүй
			Амьтны аймаг					
	Амьтны зүйлийн бүрдэл, тархалт байршлын судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт өгөх	Төслийн талбай болон түүний орчимд	7-р Уурхайн Байгаль орчны мэргэжилтэн хээрийн судалгааг хийж гүйцэтгэх 500000					-Амьтны судалгааны арга зүй
			Цацрагийн хэмжилт					
1	Уурхайн ойр орчмын бүсийн агаарт цацрагийн тун байгаа эсэхэд	-уурхайн ам орчмоос /агааржуулалтын хоолой/	5, 9 сард	2	50 000	1 цэг 100 000		

хяналт шинжилгээ хийлгэх							-	
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 2025 оны зардлын дүн						3,363,680.5		

Орчны хяналт шинжилгээний мониторингийн цэг

№	Мониторингийн цэг	UTM		DMS	
Агаар					
1	Уурхайн хотхон	559212.9506	5288051.9385	47°44'35.21"	111°47'23.51"
2	Уурхайн босоо ам	559193.6582	5287870.7166	47°44'29.35"	111°47'22.51"
Хөрс					
1	Уурхайн хотхон	559212.5523	5288070.5592	47°44'35.82"	111°47'23.52"
2	Шимт хөрсний овоолго	559159.2069	5287534.4964	47°44'18.48"	111°47'20.71"
3	Нөлөөлөлд өртөөгүй талбай	559828.1949	5287669.4341	47°44'22.63"	111°47'52.90"
Ургамал					
1	Уурхайн хотхон	559212.5611	5288077.1314	47°44'36.05"	111°47'23.52"
2	Хөрсний овоолго	559263.6854	5287622.6425	47°44'21.29"	111°47'25.75"
3	Нөлөөлөлд өртөөгүй талбай	559828.3073	5287651.8261	47°44'22.05"	111°47'52.89"
Ус					
1	Худаг			47°44'16"	111°47'13"

БҮЛЭГ ХIII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Далд уурхайн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг байгаль орчны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны мэргэжилтэнд хариуцуулан дээж авч шинжлүүлэх, Мэргэжлийн эрх бүхий байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах, үр дүнг тайлагнан, эрх бүхий байгууллагаар батлуулах
- Гал, үер ус, байгалийн бусад гамшгийн аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч, санамж, анхааруулах самбар хийж байрлуулах
- Байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх,

- Компанийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу үйлдвэрийн үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ,
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, гал түймэр, салхи, шуурга) болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1 удаа сургаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллана.
- Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх.

Хүснэгт 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар	Сар	Сар		
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчин хариуцсан мэргэжилтэнг захирлын тушаалаар томилох, байгаль орчны асуудал хариуцан ажиллах	Дотоод зардал	Тухай бүр	-	-	Компанийн удирдлагууд	
2	Ашиглалтын үеийн хайгуулын ажлын төлөвлөгөөг батлуулах	Дотоод зардал	Хайгуул хийх нөхцөл үүссэн үед	-	-	Геологич	
3	Уулын ажлын төлөвлөгөөг батлуулах	Дотоод зардал	4 сард	-	-	геологич	
4	Тухайн жилийн БОМТ-г батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах	Дотоод зардал	5 сард	-	-	ХАБЭА-ын ажилтан Байгаль орчны мэргэжилтэн	
5	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”-аар ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах	Дотоод зардал	БОННУ-нд тодотгол орох тохиолдолд	-	-	Мэргэжлийн байгууллага	
6	Болзошгүй аюул ослын үед ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах	1000.0	5 сард	-	-	ХАБЭА-н ажилтан	
7	Өвөлжилт хүндэрсэн үед нутгийн иргэдэд өвс, хадлангийн тусламж үзүүлэх	2000.0	Орон нутгийн санал	-	-	Удирдлагууд	

8	БО-г хамгаалах, ХАБЭА, ШТМ-ын асгаралт, хадгалалт, ашиглалт, устгалын чиглэлээр өөрийн ажилтан, ажилчдын дунд улирал тутамд сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, Өдөр тутамд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Дотоод зардал	Сар бүр	-	-	ХАБЭА-н ажилтан	
9	Байгаль орчныг хамгаалах мэдээ мэдээлэл, сурталчилгааны самбар хийж байнгын цахим мэдээллээр хангах	1000.0	8 сард	-	-	БОМэргэжилтэн	
10	Орон нутгийн удирдлага болон иргэдэд төслийн үйл ажиллагааны биелэлт, байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийн талаар танилцуулга, хэлэлцүүлгийг тогтмолт хийж байх	Дотоод зардал	6, 9 сард	-	-	Уурхайн дарга БОМэргэжилтэн ХАБЭА-н ажилтан	
11	Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчны аудитыг төслийн 2 дахь жилээс ⁴ /2 жил тутамд/ хийлгэж аймаг нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлэх ⁵	Дотоод зардал	2 жилд 1 удаа	-	-	Удирдлагууд БОМэргэжилтэн	
Нийт зардал		4000.0	-				

БҮЛЭГ XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм. Биологийн нөхөн сэргээлтийг орон нутгийн холбогдох

⁴ Байгаль орчныг хамгаалах тухай хууль 10¹-р зүйл

⁵ Ерөнхий үнэлгээний дүгнэлт Онцгойлон анхаарах зүйлс /8/

мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгөх бөгөөд холбогдох тайлан, төлөвлөгөөг Төрийн захиргааны төв байгууллагаар цаг тухайд нь батлуулан, орон нутгийн иргэдэд тайлагнах ажлыг 10 сард багтаан хийж гүйцэтгэнэ.

“Ханшашир” ХХК-ийн Дожир жоншны хүдрийн ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн Уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **48,145,680.5 мян.төг** зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 10. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7
Хэнтий аймгийн Баян-Овоо сумын багийн ИНХ	Сумын багийн ИНХ-аар илтгэл тавьж мэдээлэл өгөх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл	БИНХ-ын тов зарласан үед	ҮАЗ-д	Уурхайн дарга БОМэргэжилтэн	Багийн төвд
Аймгийн БО-ны газар	БОМТ биелэлтийн тайланг тайлан хэлбэрээр хүргүүлэх, биелэлтийн тайлан дүгнэх ажлын хэсгийн хамт газар дээр нь танилцуулах	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт	Хуулийн хугацаанд 11-р сарын 1	ҮАЗ-д	Ерөнхий геологич Уурхайн дарга БОМэргэжилтэн ХАБЭА-н ажилтан	Дожир уурхайд
БОУАӨЯам	БО-г хамгаалах ажлын жилийн тайлан, төлөвлөгөө БОУАӨЯ –нд цаг тухайд нь гаргаж өгч байх	Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, төлөвлөгөө	12 сард	ҮАЗ-д	Ерөнхий геологич БОМэргэжилтэн	БОУАӨЯам